



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН-2017 ОН

ТАНЫ ОРОЛЦОО-ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭС

Агуулга

Агуулга

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан	3-4
Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн засаглал	4-6
Сангийн бүтэц, зохион байгуулалт	4
Сангийн Удирах зөвлөл	5
Харилцааны хороо.....	6
Говийн Оюу хөгжлийг дэмжих санд хүлээн авах төсөл, хөтөлбөрийн саналын чиглэл...	7-11
Санхүүжилт олгох үндсэн чиглэл.....	7
Ирээдүй хойч үеийн төлөө сан.....	8
“Говийн Оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр	9-11
Батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт.....	12-14
Сангийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрүүд.....	12
Сангийн 2017 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт.....	13
Сангийн 2017 оны онцлох үйл явдал.....	14
Сангаас батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	15-73
<i>2017 онд батлагдсан төсөл хөтөлбөрийн жагсаалт</i>	<i>15-16</i>
<i>Нийгмийн дэд бүтцийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт</i>	<i>17-30</i>
<i>Байгаль орчны менежментийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт.....</i>	<i>31-36</i>
<i>Нийгмийн суурь үйлчилгээний чиглэлийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт</i>	<i>37-56</i>
<i>Мал аж ахуйн чиглэлийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт</i>	<i>57-60</i>
<i>Үндэсний түүх соёл, аялал жуулчлалын чиглэлийн хөтөлбөрийн хэрэгжилт.....</i>	<i>61-68</i>
<i>Орон нутгийн бизнес хөгжил чиглэлийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт.....</i>	<i>69-70</i>
<i>Тендерийн үе шатанд байгаа төсөл хөтөлбөрүүд.....</i>	<i>71-72</i>
Харилцагч байгууллагууд	73
Санхүүгийн тайлан.....	74-77
Төсөл хөтөлбөрүүдээс үр шим хүртэгчдийн сэтгэгдэл.....	78-81
Хавсралт	
Аудитын дүгнэлт	82-107



Алсын хараа

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ

Эрхэм зорилго

Өмнөговьчуудын сайн сайхан амьдралыг дэмжсэн хамтын хөгжлийн санаачлагыг санхүүжүүлэгч сан байна

Эрхэмлэх зарчим

1. Авилгалаас ангид байх
2. Хувийн ашиг сонирхлоос ангид байх
3. Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
4. Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
5. Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх
6. Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сум болон “Оюутолгой” ХХК-ийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс “Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан” Төрийн бус байгууллагыг 2015 оны 09 сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК нь жил бүр 5 сая ам.доллар түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн Оюу ХДС”-д олгодог. “Говийн Оюу ХДС” нь эрүүл мэнд, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэргээр аймгийн болон Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах зохион байгуулах зорилготой ажиллаж байна.

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗАСАГЛАЛ САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сангийн эрх барих дээд байгууллага болох Удирдах зөвлөл нь Өмнөговь аймаг, Ханбогд сум болон Оюутолгой компанийн төлөөлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй.

Сангийн хяналтын зөвлөлийн үүргийг хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх хэрэгжүүлдэг бол Гүйцэтгэх захиралаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлдэг.

Хуулийн хүрээнд байгуулсан дээрх бүтэцээс гадна талууд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд харилцан ойлголцол хамтын ажиллагааг дэмжих зохицуулах үүрэг бүхий Харилцааны хороог байгуулсан ба Харилцааны хороо нь Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх үүрэгтэй. Харилцааны хороо нь нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй, Оюутолгой компанийн төлөөлөл 4 хүн, орон нутгийн төлөөлөл 9 хүн сонгогдон ажиллаж байна. Оюутолгой компанийн төлөөлөлийг Хангамж, хүний нөөц сургалт, байгаль орчин, орон нутгийн харилцаа гэсэн орон нутагтай илүү хамтран ажиллах шаардлагатай хэлтэс албадын төлөөлөл байдаг бол орон нутгийн зүгээс сумдын удирдлага, аймгийн салбар хариуцсан хэлтэс агентлагийн удирдлага иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлөөс бүрдэн ажиллаж байна.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ СЭДЭВЧИЛСЭН ХАВСРАЛТУУДЫН ДАГУУ ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНД ХҮЛЭЭН АВАХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНАЛЫН ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагааны гэрээ нь Өмнөговь аймаг, Ханбогд сум болон Оюутолгой компаниуд нь хамтран ажиллахаар тогтсон дараах сэдэвчилсэн хавсралтуудтай. Үүнд

- Усны менежмент
- Байгаль орчны менежмент
- Уламжлалт мал аж ахуй бэлчээрийн менежмент
- Үндэсний түүх соёл ба аялал жуулчлал
- Нийгмийн суурь үйлчилгээ /эрүүл мэнд боловсрол, сургалт/
- Нийгмийн дэд бүтэц ба хөрөнгө оруулалт

Эдгээр үндсэн чиглэлүүдээр Өмнөговь аймагт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн саналыг хүлээн авч шалгаруулан нийгэмд илүү их үр өгөөж өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхүйц төсөл хөтөлбөрүүдийг сонгон буцалтгүй санхүүжилт олгодог.

Харин Хамтын ажиллагааны гэрээний нөгөө нэг сэдэвчилсэн хавсралт нь “Орон нутгийн бизнес хөгжил ба бараа үйлчилгээ худалдан авалт” гэсэн сэдэвтэй бөгөөд энэ чиглэлийн хүрээнд орон нутгийн бизнесийг дэмжих харьцангуй ашгийн төлөө үйл ажиллагаа дэмжих шаардлагатай тул дээрх нийгмийн чиглэлүүдээс өөрөөр банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжих зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Г ОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗАСАГЛАЛ

Оюу толгой ХХК, Өмнөговь аймаг, Ханбогд сумын хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу Талуудын оролцоог хангах зорилгоор Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн бүтцэд Удирдах зөвлөл болон Харилцааны хороо гэх хоёр бүтэцээр Өмнөговь аймагт нэн тэргүүний, хэрэгцээ шаардлагатай байгаа төсөл хөтөлбөрүүдийг хэлэлцүүлэн сонгон шалгаруулж, санхүүжилт олгох бүхий л үе шатанд орон нутаг болон Оюу толгой ХХК-ийн төлөөллийг хамтран ажиллаж байна.

САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Удирдах зөвлөл нь Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөл 7 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум

хамтран орон нутгийн 3 гишүүнийг, үүлж Оюу толгой ХХК-иас 4 гишүүнийг нэр дэвшүүлж Удирдах зөвлөлийг гишүүдийг томилсон.

Сангийн удирдлагыг сайжруулах болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн Дүрмийн дагуу удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх, сангийн дүрмийн хэрэгжилтийг сахиулах эрх бүхий хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх томилогдон ажиллаж байгаа.



Стефен Жонс
Удирдах зөвлөлийн дарга



Б.Баяр
Сангийн Итгэмжлэгдсэн зөвлөх



ХАРИЛЦААНЫ ХОРОО

Сангийн Харилцааны хороо нь Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Өмнөговь аймаг, Оюу толгой ХХК болон сангаас хамтран ажиллах Түншлэгч сумдын харилцаа хамтын ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой бүтэц бүрэлдэхүүн юм. Харилцааны хороо 13 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж орон нутгийн 9 төлөөлөгчийг томилж Оюу толгой ХХК-иас нэр дэвшүүлж ОТ-ХХК-ийн 4 гишүүнийг дараах байдлаар томилон ажиллаж байна.



Х.Батболд



Ө.Баянмөнх



Ж.Сүх-Эрдэнэ




Ү.Энхцацрал



О.Мандахбаяр



Б.Дэндэвсамба



Г.Буянхүү



А.Оюунтуяа



В.Мөнхбат



Ш.Байгалмаа



Л.Удвал



Д.Амартүвшин



Н.Эрдэнэбаяр


ГОВИЙН ОЮУ ХДС-Д ХҮЛЭЭН АВАХ САНАЛЫН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР

САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагааны гэрээний дагуу Талууд үүрэг амлалт хүлээсэн ба Оюу толгой ХХК нь нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн сүүр үйлчилгээ, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэднээс бараа үйлчилгээ худалдах авах гэсэн 7 Сэдэвчилсэн чиглэлээр Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар харилцан тохиролцсон.

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь иргэд байгууллагуудаас дээр дурьдсан нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн сүүр үйлчилгээ гэсэн 6 чиглэлийн Өмнөговь аймагт хэрэгжих төсөл хөтөлбөрийн санал хүлээн авч Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Өмнөговь аймагт нэн тэргүүний, хэрэгжүүлэх шаардлагатай төсөл хөтөлбөрийг шалгаруулж санхүүжилт олгодог.

Орон нутгийн бизнес хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалтын чиглэлийн төслүүдэд санхүүжилт олгохдоо бид Хаан банктай гэрээ байгуулж бичил зээлийн үйлчилгээг хариуцуулснаар жил бүр бизнесээ шинээр эхлүүлэх болон өргөжүүлэх зорилготой Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдэд 30 сая хүртэлх төгрөгийн 1%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээл санал болгож төслийн уралдаан зарлаж шалгаруулж байгаа.



ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН



Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн Ирээдүй хойч үеийн төлөө сангийн хөрөнгөөр ХААН банкнаас Оюутолгой төслийн түншлэгч сумдын Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төслийн зээлийг амжилттай хэрэгжүүлж байна.


Уг төслийн зээлийн хүрээнд Даланзадгад, Ханбогд, Манлай, Баяновоо сумдын **11** иргэнд **203,520,000** төгрөгийн зээл олгосон.



ГОВИЙН ОЮУ- ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ

Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас Өмнөговь аймгийн ирээдүй хойч үеийн төлөө зориулан хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөрүүдийн нэг нь “Говийн оюу – Оюутны тэтгэлэг” хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг 2017 онд 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Өмнөговь аймгийн “Говийн ухаан” төрийн бус байгууллагыг “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн Удирдах байгууллагаар сонгов.
- Өмнөговь аймгийн ЗДТГ-аас Өмнөговь аймагт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн чиглэлийг санд ирүүлсэний дагуу аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтэс, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн төлөөлөл болон “Говийн ухаан” төрийн бус байгууллагаас бүрдсэн сонгон шалгаруулах хороо байгуулагдаж, 2017-2018 оны хичээлийн жилд тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.
- “Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2017 онд улсын болон магадлан итгэмжлэгдсэн сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 57 оюутанд 105,215,602 төгрөгийн тэтгэлэг олгосон.



- Сургуулийн өмнөх болон төрөл мэргэжлийн багш - 21
- Хүний их эмч, сувилахуй, эмнэлгийн мэргэжилтэн - 28
- Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэн - 11
- Уул уурхайн инженер, техникийн ажилтан - 13
- Барилгын салбарын мэргэжилтэн – 11
- Нийгмийн ухаан – 2
- Байгалийн ухаан -1

/Давхардсан тоогоор 87 оюутан тэтгэлэгт хамрагдсан байна /

2017 ОНД “ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУД



Алтанцог АЛТАНТУЯА
Хүмүүнлэгийн их сургууль
Англи хэлний багш
(Баян-Овоо)



Банзрагч АЛТАНЦЭЦЭГ
АШУУИС-н Дорноговь салбар
Сувилахуй арга зүй
(Ханхонгор)



Алтанбагана АНАНД
АШУУИС
Шүдний эмч
(Даланзадгад)



Эрхэмбаатар АЗЗАЯА
АШУУИС
Эх баригч
(Даланзадгад)



Идэр БАДАМХАНД
Оточ Манрамба Их сургууль
Эм зүйч
(Ханхонгор)



Эрдэнэ-Очир БИЛГҮҮН
ШУТИС
Барилгын инженер
(Даланзадгад)



Цэнджаргал БУМАНЗАЯА
Шинэ АУДС
Уламжлалт АУ-ны эмч
(Баян-Овоо)



Эрдэнэбямба БҮРЭНЧУЛУУН
МУБИС
Багш
(Цогт-Овоо)



Энхтөр БУЯНДЭЛГЭР
ХААИС
Байгаль орчныг хамгаалах
технологи (Даланзадгад)



Ган-Олз БУЯНЖАРГАЛ
МУБИС
Багш
(Даланзадгад)



Баярсайхан ДАВААСҮРЭН
ШУТИС-БУХС, Жижиг дунд
үйлдвэрлэлийн менежмент
(Даланзадгад)



Бүрэн-Отгон ЖАВЗАНДУЛАМ
ХААИС, Байгаль орчныг хамгаалах
технологи
(Баяндалай)



Энхсолонго ЛХАГВА-ОЧИР
МУБИС
Технологийн багш
(Даланзадгад)



Цог МААМ
МУБИС
Химийн багш
(Манлай)



Ганбат МӨНГӨНЦЭЦЭГ
АШУУИС
Эх барихуй
(Даланзадгад)



Мөнхбат ОТГОНЦЭЦЭГ
АШУУИС
Хүний их эмч
(Цогтцэций)



Адъяадорж ОТГОНЧИМЭД
Газарчин дээд сургууль
Бага ангийн багш
(Манлай)



Бат-Өлзий ОЮУН-ЭРДЭНЭ
АШУУИС
Лабораторийн техникч
(Баяндалай)



Дангаасүрэн ПАГАМДУЛАМ
ХААИС
Газар зохион байгуулагч
(Даланзадгад)



Түмэн-Өлзийн Сайнбаян
АШУУИС
Хүүхдийн их эмч
(Ханбогд)



Батболд ТҮВШИНБАЯР
Үндэсний техникийн их сургууль
Архитектур
(Манлай)



Мөнхжаргал ТУУЛАЙХҮҮ
ХААИС
Агрономич
(Даланзадгад)



Насанбаяр ТҮВШИНСАНАА
Үндэсний биеийн тамирын дээд
сургууль, Биеийн тамирын багш
(Сэврэй)



Сүрэнхүү УДВАЛ
АШУУИС- Монгол анагаах ухааны
олон улсын их сургууль Уламжлалт
анагаахын их эмч
(Баяндалай)



Баярсайхан УУГАНБАЯР
МУИС-Шинжлэх Ухааны Сургууль,
Багш, нийгмийн ухааны боловсрол
(Цогт-Овоо)



Туул ЧУЛУУНЧИМЭГ
АШУУИС, Нүүр ам оогог судлал
Шүдний их эмч
(Мандал-Овоо)



Батмөнх ШИЖИРТУЯА
МУБИС/Архангай/
Багш
(Даланзадгад)



Насанжаргал ШИНЭ-ЭРДЭНЭ
ШУТИС-БИАС
Барилгын инженер
(Булган)



Батжаргал ШҮРЭНЦЭЦЭГ
АШУУИС
Шүдний эмч
(Даланзадгад)



Будсүрэн ЭРДЭНЭТӨГС
ШУТИС
УУТТ-ийн инженер
(Даланзадгад)



Өлзийбаатар БАТБАЯР
ШУТИС-Геологи Уул Уурхайн Сургууль
Уул уурхайн маркшейдер
(Даланзадгад)



Баттулга БАТ-ЭРДЭНЭ
БХИС
Барилгын инженер
(Даланзадгад)



Цогбаатар БАТЛХАГВА
ШУТИС /Коосан ТДС/
Механикийн инженер
(Ханбогд)



Энхтөр БИЛЭГДЭМБЭРЭЛ
ШУТИС Уул уурхайн
ашиглалтын технологи
(Даланзадгад)



Цэвэлмаа БОЛОРТУЯА
ХААИС Бүтээгдэхүүний чанар
ариун цэврийн хяналт үнэлгээ
(Даланзадгад)



Хүрэлтулга БЯМБАДЭЛГЭР
Их засаг, Дүрслэх урлаг
дизайн технологийн сургууль
Архитектур (Даланзадгад)



Энхжаргал ГАНЧИМЭГ
МУБИС
Түүх, нийгмийн ухааны багш
(Даланзадгад)



Дэлжэргат ГЭРЭЛМАА
МУБИС
Багш
(Ханхонгор)



Энхмандах ДАВААБИЛЭГТ
МУИС
Хот ба бус нутагт төлөвлөлт
(Даланзадгад)



Төгсөө ДАВААНЯМ
ШУТИС-Геологи Уул Уурхайн
Сургууль, Уул уурхайн
ашиглалтын технологи
(Даланзадгад)



Тогтох НАДМИД
Этүгэн ИС
Их эмч
(Ноён)



Түмэнбаяр НАНДИНЦЭЦЭГ
ХААИС
Газар зохион байгуулагч
(Даланзадгад)



Буян-Өлзий НАРАНЦЭНГЭЛ
МУБИС
Англи хэлний багш
(Даланзадгад)



Сайнжаргал НАРАНЧИМЭГ
АШУУИС /Дорноговь/
Их эмч
(Даланзадгад)



Мэндбаяр НОМИНЗУЛ
ШУТИС-УТС
Ноос ноолуурын инженер
(Даланзадгад)



Олзбаатар САРНАЙЦЭЦЭГ
АШУУИС, Нүүр ам согог судлал
Шүдний их эмч
(Даланзадгад)



Энхжаргал САРНАЙЦЭЦЭГ
ХААИС Байгаль орчныг
хамгаалах технологи
(Даланзадгад)



Цэрэнтогтох СУГИРЖАВ
МУБИС, Хятад, англи хэлний багш,
орчуулагч
(Баяндалай)



Алдарбаяр ТАЙВАНЖАРГАЛ
МУИС
Сэтгэл судлал
(Даланзадгад)



Алтансүх ТАМИРАА
ХААИС
Газар зохион байгуулагч
(Даланзадгад)



Олуунбилэг ХИШИГЖАРГАЛ
АШУУИС /Дорноговь
Сувилахуй
(Манлай)



Төртөгтох ХУЛАН
АШУУИС-н Дорноговь салбар
Хүний их эмч
(Даланзадгад)



Анхбаяр ЦОГБАТ
МУИС
Архитектур
(Баяндалай)



Батцэнгэл ЦЭЦЭГМАА
МУБИС
Бага боловсролын багш
(Номгон)



Мөнхцацралт ЧАНЦАЛЛАХАЙ
АШУУИС-н Дорноговь салбар
Их эмч
(Даланзадгад)



Ундармаа ЭНХТҮВШИН
СИТИ их сургууль
Архитектур
(Даланзадгад)



Бат-Эрдэнэ ЯНЖИНЛХАМ
МУБИС
СӨБ багш
(Даланзадгад)


У ДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН САНАЛУУД

2017 онд Говийн Оюу хөгжлийг дэмжих санд нийт 164 төсөл санал ирснээс Сангийн Удирдах зөвлөл Сангийн санхүүжилтийн удирдамж, шалгуур, Өмнөговь аймгийн нэн тэргүүний чиглэлтэй нийцсэн 37 төсөл хөтөлбөрийн саналыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.


Говийн Оюу хөгжлийн дэмжих сангийн 2017 онд хүлээн авсан төсөл хөтөлбөрийг чиглэлээр нь дараах байдлаар харуулж байна.




Говийн Оюу хөгжлийг дэмжих сангаас 2017 онд санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн хуваарилалтыг дараах байдлаар харуулж байна.



ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН СТАТИСТИК МЭДЭЭ, 2015-2017 ОНД ӨМНӨГОВЬ АЙМАГТ ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




2015-2017 онд нийт 289 санал хүлээн авсан



Нийт хамтарсан санхүүжилт- 2,5 тэрбум төгрөг /1 сая ам.доллар




2015-2017 онд нийт 109, 2 мянган хүнд үр өгөөж өгөх төсөл санхүүжүүлсэн



2015-2017 онд нийт 26,7 тэрбум ₮/ 10,9 сая ам.долларын төсөл санхүүжүүлэв




Нийт 79 хувь хүн, байгууллага, аж ахуй нэгжтэй хамтран ажилласан



2015-2017 онд нийт 358,1 сая ₮/146,2 мян ам.долларын хандив үзүүлэв



2016-2017 онд нийт 11 бизнес эрхлэгчдэд зээл олгов





2015-2017 онд нийт 65 төсөл баталсан



2016-2017 онд нийт 87 оюутанд тэтгэлэг олгов



2015-2017 онд 2 дахь удаа аудитад орсон



САНГИЙН 2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ



Удирдах зөвлөлийн хурал

- 2017.03.28
- 2017.07.05
- 2017.10.02
- 2017.12.01



Хэлэлцүүлэг

- 2017.05-Орон нутгийн жижиг дунд бизнесхөгжил сэдэвт
- 2017.09- Бэлчээр, усны менежмент сэдэвт
- 2017.11-Байгаль орчин, Үндэсний түүх соёл болон Боловсрол, мэргэжлийнхн сургалт сэдэвт



Аудитадын үйлчилгээ авав

- 2017.11.06- 12.08

Харилцааны хороо хурал

- 2017.03.14
- 2017.05.30
- 2017.08.23
- 2017.11.08

Говийн Оюу-Оюутны тэтгэлэг

- 2017.09.17- 57 оюутан тэтгэлэгт хамрагдсан

Уул уурхайн зөвлөгөөн

- 2017.11.11-12



**САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ**

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Санжүүжилт
Нийгмийн дэд бүтэц		
1	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ	350,000,000
2	Ханбогд сумын Дулаан хангамж	365,729,260
3	Ханбогд суман дахь сум дундын малын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж болон бусад нэмэлт ажил	333,414,245
4	Сургуулийн дотуур байрны зураг боловсруулах	25,000,000
5	Даланзадгад сумын Төвийн хэсгийн автозамын гадаргуугийн ус зайлуулах шугам	1,362,463,752
6	Сургуулийн нийтийн бие засах газар	39,650,000
7	Ханбогд суманд үерийн далан байгуулах ажлын зураг төсөл, төсөв	49,822,097
8	Мах жижиглэн ангилах, хиамны үйлдвэр	975,000,000
9	Даланзадгад сумын 11-р цэцэрлэгийн дэргэдэх 100 хүүхдийн цэцэрлэг	450,000,000
10	Сургууль цэцэрлэгийн цогцолборын үлдэгдэл санхүүжилт	3,857,498,501
	Дэд дүн	7,808,577,855
Байгаль орчны менежмент		
1	Сэврэй сумын Говийн төгөл	7,577,700
2	Хог хаягдлыг бууруулах Цэмцгэр Даланзадгад	40,500,000
3	Ханбогд сумын хог хаягдлын менежмент	593,429,508
4	Даланзадгад сумын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох төсөл болон холбогдох барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах ажил	187,145,200
	Дэд дүн	828,652,408
Нийгмийн суурь үйлчилгээ		
1	Ирээдүйд гэрэлтэх нас	63,271,000
2	Цахим багш	18,915,000
3	Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн STEAM хөтөлбөр	6,450,000
4	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	205,000,000
5	Багшийн хөгжил	150,000,000
6	Мөрөөдлийн зүг хамтдаа	34,695,000
7	Хөгжлийн ирээдүй-Оюунлаг залуучууд	76,355,400
8	Ахмадуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх	76,903,416
9	Мэдээлэл технологийн кабинет	24,789,050
10	Дизайн технологийн кабинет	10,998,483
11	Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багаж тоног төхөөрөмжийн хүрэлцээ нөлөөлөх нь	49,700,000
12	БОЭТ-ийн шүдний кабинет тохижуулах	138,279,838
13	Аюулгүй хашаа	49,553,600
14	Ахмад настанд ээлтэй орчин	49,195,000
15	Зөвлөх профессорын баг	109,394,000
16	Өмнөговь аймагт 2020 он хүртэлх яаралтай болон мэс заслын тусламжийг чадавхжуулах	450,000,000

		Дэд дүн	1,513,499,787
Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент			
1	Шилмэл сүрэг		138,283,840
2	Бэлчээр эрдэнэ		320,000,000
		Дэд дүн	458,283,840
Үндэсний түүх соёл, аялал жуулчлал			
1	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах		80,000,000
2	Зан заншил-сургалт		36,220,000
3	Зөөлөн сандал, мэргэжлийн гэрэлтүүлэг		149,800,000
4	Хөдөөгийн соёл-хөгжлийн түүчээ		21,015,600
		Дэд дүн	287,035,600
Усны менежмент			
1	Гашуун сухайт боомтын ундны усыг цэвэршүүлэх байгууламж		112,800,000
		Дэд дүн	112,800,000
Орон нутгийн бизнес хөгжил			
1	Өмнөговь аймгийн хүлэмжийн аж ахуйн цогцолбор хөгжүүлэх		199,578,400
		Дэд дүн	199,578,400
Бусад			
	Хандив тусламж		498,447,297
	Ирээдүй хойч үеийн төлөө сан		621,118,244
	ХДС-ийн үйл ажиллагааны зардал		298,551,018
		Дэд дүн	1,418,116,559
	НИЙТ ДҮН		12,626,544,449

Тайлбар:

Дээрх төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн дүн нь Сангийн Удирдах зөвлөлөөс баталсан, зарим төсөл хөтөлбөрийн хувьд тендер шалгаруулалтын үр дүнгээр байгуулсан санхүүжилтийн гэрээний дүн болно.

Учир нь Говийн Оюу хөгжлийг дэмжих сан нь Сангийн Удирдах зөвлөлөөс баталсны дагуу төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг.

Хэрэв төсөл хөтөлбөрүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үр дүнгээр Удирдах зөвлөлөөс батлагдсан үнийн дүнгээс санхүүжүүлэх гэрээний дүн хэмнэгдсэн тохиолдолд хэмнэгдсэн санхүүгийн эх үүсвэрээр дараагийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ажилладаг.

2017 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БУЙ НИЙГМИЙН НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨСӨЛ:

ХАНБОГД СУМЫН СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОР БАРИЛГА БАРИХ



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨСӨВ

6,079,828,009 ТӨГРӨГ




ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Ханбогд сумын ерөнхий боловсролын
сургуулийн 640 хүүхэд, цэцэрлэгийн 200 хүүхэд

Төслийн үндэслэл

360 хүүхдийн хүчин чадалтай сургуульд 970 хүүхэд, 300 хүүхдийн цэцэрлэгт 420 хүүхэд сурч, хүмүүжиж байна. Мөн түүнчлэн тус сургууль цэцэрлэгийн анги дүүргэлт 40 хүүхэдтэй, цэцэрлэгт 208 хүүхэд хамрагдаж чадахгүй байна.



Төслийн зорилго

Ханбогд сумын төвд орчин үеийн шаардлагад нийцсэн инженерийн иж бүрэн дэд бүтэцэд холбогдсон сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга баригдаж тус сумын хүүхдүүд ая тухтай орчинд сурч боловсрох нөхцлөөр хангагдах юм.

Төслийн хүрээнд хийгдэх ажил

640 хүүхдийн сургууль, 200 хүүхдийн цэцэрлэгийн цогцолбор барилга баригдана. Тус цогцолбор барилгад урлаг, спортын заал, хүйтэн болон дулаан агуулах бүхий гал тогооны танхим, чийрэгжүүлэх танхим, өдөр өнжүүлэх төв, гадна тоглоомын талбай, хөл бөмбөгийн талбай зэргийг цогцоор шийдвэрлэсэн бөгөөд цэвэр, бохир, дулаан, цахилгаан зэрэг инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдоно.

Төслийн үр өгөөж

Ханбогд сум төдийгүй Өмнөговь аймгийн хэмжээнд сангаас санхүүжүүлж буй нийгмийн дэд бүтэцийн томоохон төслүүдийн нэг уг цогцолбор 2018 оны 3-р улиралд ашиглалтанд орсноор:

- Ханбогд сумын сургууль, цэцэрлэгийн 840 хүүхэд ая тухтай орчинд сурч, хүмүүжих нөхцөл бололцоогоор хангагдана
- 640 хүүхдийн сургуульд 73 багш, ажилчид ажиллах ажлын байр нэмэгдэнэ
- 200 хүүхдийн цэцэрлэгт 30 багш, ажилчид ажиллах ажлын байр нэмэгдэнэ
- Тус суманд нийт 103 ажлын байр бий болно
- Тус цогцолборын барилгатай хамт сумын төвд 3000м орчим халаалтын болон цэвэр бохирын шугам хоолойн дэд бүтэц бий болж байгаа ба бусад байгууллага аж ахуйн нэгж, айл өрх инженерийн шунам хоолойд холбогдох бололцоотой болно

**ХАНБОГД СУМЫН СУМ ДУНДЫН МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДСЭН
ТӨВИЙН БАРИЛГА**



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

**ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



ТӨСӨВ

1,452,745,569 төгрөг




ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

**Ханбогд, Манлай, Баян-овоо, Цогтцэций сумдын
1554 малчин өрх төдийгүй хил залгаа аймгийн
малчид**

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр малын тоо толгой эрс нэмэгдэж байна. Өмнөговь аймгийн статистикийн тоо мэдээнээс харахад сүүлийн 5 жилд малын тоо толгой 1 саяар нэмэгдэж 2017 оны жилийн эцсийн байдлаар 2.6 сая мал тоолуулжээ. Дээрх нөхцөл байдалтай холбоотой бэлчээрийн даац хэтрэх, малын халдварт нэмэгдэх, үүлдэр угсаа нь муудаж ашиг шим нь буурах улмаар мал аж үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар муудах зэрэг тулгамдсан асуудлууд гарсаар байна



Төслийн зорилго

Өмнөговь аймгийн зүүн бүсийн 4 сумын мал аж ахуйн үйлдвэрлэлийг уламжлалт арга барил, дэвшилтэт технологитой хослуулан жишиг байдлаар хөгжүүлж тухайн бүс нутагт малын эрүүл мэнд, үүлдэрлэг байдлыг сайжруулан мал аж ахуйгаас үйлдвэрлэх бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар, малчдын орлого, амжиргааны түвшинг нэмэгдүүлэх зорилготой юм.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Ханбогд сумын төвд малын эрүүл мэндийн төвийн барилга, 4 машины граж, 4 айлын ажилчдын сууц, малын саравч, хашаа зэргийг барьж байгуулан тус төвд шаардлагатай 133 нэр төрлийн лабораторийн багаж тоног төхөөрөмж, оффиссын тавилга хэрэгсэл нийлүүлсэн.

Төслийн үр өгөөж

- Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-овоо, Цогтцэций сумдын 1554 малчин өрх төдийгүй хил залгаа аймгийн малчид мал эмнэлгийн тусламж үйлчилгээ авах бололцоотой болно
- Малчдын малын эрүүл мэнд, чанарын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мал маллагааны удирдлага сайжирна
- Мал эмнэлгийн үйчилгээ сайжирна
- 4 сумдад эмнэлэг барихад гарах давхардсан зардал багасна
- Хүнсний аюулгүй байдлын талаарх ойлголт нэмэгдэнэ
- Тус төв нь мал эмнэлэг, үржүүлэг, лабораторийн үйлчилгээ үзүүлж Өмнөговь аймгийн зүүн бүсийн 4 сумын малын эрүүл мэнд, чанар сайжирна
- Ханбогд суманд шинээр 4-5 ажлын байр нэмэгдэнэ

МАНЛАЙ СУМЫН УУРЫН ЗУУХ



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨСӨВ

929,150,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Манлай сумын төвийн албан байгууллага, аж
ахуй нэгж, иргэд, сургууль, цэцэрлэгийн
хүүхдүүд үр шимийг хүртэнэ

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Манлай сумын төвд томоохон барилга байгууламжууд нэмэгдэн баригдаж хуучин уурын зуухны хүчин чадал хүрэлцэхгүйд хүрсэн. Мөн түүнчлэн хуучин уурын зуух нь сумын төвийн “А” зэрэглэлд буюу цэцэрлэгийн барилгаас 17м, дотуур байрнаас 28м, сургуулийн барилгаас 33м-ийн зайд мөн 100 гаруй айл өрхийн дунд байрлалтай байгаа нь сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд, иргэдийг нүүрс, үнс, уурын зуухны утаа зэрэг бохирдлоор бохирдуулж цаашлаад ханиад томуу, уушигны архаг өвчлөлүүдийг үүсгэх эрсдэлтэй байна.



Төслийн зорилго

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэглэгчдийн шаардлагатай дулааны хүчин чадалд нийцүүлэн хүн амын нийгмийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартад нийцсэн уурын зуухны барилгыг сумын төвөөс боломжит зайд барьж сургууль, цэцэрлэгийн хүүхэд, тус бүсийн иргэдийн эрүүл агаартай орчинд амьдрах, сурч, хүмүүжих нөхцлийг сайжруулна. Мөн түүнчлэн уурын зуухны тогооны хүчин чадал нэмэгдсэнээр дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох айл өрхийн тоо нэмэгдэнэ.

Төслийн хүрээнд хийсэн ажил

- 165м² -цутгамал карказан барилга, тоосгон өрлөгтэй уурын зуухны барилга
- Халаалтын тогоо / 1.6мвт/ -2ш
- Гадна хашаа /50.4мх60.1м/ - 221м
- Цахилгааны дэд өртөө10/0.4кВ -ийн 250 кВа дэд өртөө,
- Гадна цахилгааны шугам - 844м
- Гадна дулаан, цэвэр усны шугам - 760м
- Гадна бохир усны шугам - 13.2м
- Бохирын цооног - 10м³

Төслийн үр өгөөж

- Шинэ уурын зуухыг халаалтын төвлөрсөн системд холбож ашиглалтанд оруулснаар хүчин чадал нь одоо ашиглагдаж байгаа уурын зуухны хүчин чадлаас 2 дахин нэмэгдэнэ
- Манлай сумын айл өрхүүд халаалтын төвлөрсөн системд холбогдох боломжтой болно
- Сумын төвд сургууль цэцэрлэгийн дунд байрласан байсан уурын зуухны бохирдол байхгүй болно
- Иргэдийн эрүүл мэнд сайжирна

ХАНБОГД СУМЫН ДУЛААН ХАНГАМЖ БАРИХ



ЗАХИАЛАГЧ: ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

ТӨСЛИЙН УДИРДЛАГА



382,352,268 ТӨГРӨГ

ТӨСӨВ



Ханбогд сумын төвийн албан байгууллага, аж
ахуй нэгж, иргэд, сургууль, цэцэрлэгийн
хүүхдүүд үр шимийг хүртэнэ

ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Ханбогд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын хойд дэнжид баригдсан ЗДТГ-ын барилга, соёлын төв, нийгмийн даатгал, цэцэрлэгийн барилга, 5 давхар орон сууцны барилга, иргэдийн хөгжлийн төв зэрэг сүүлийн жилүүдэд нэмэгдэж баригдсан нийт 9 томоохон барилга хуучин уурын зуухны тогооны хүчин чадал хүрэлцдэггүйгээс төвлөрсөн дулаан системд холбогдоогүй. Тус суманд барилгууд бие даасан халаалтын системтэй байгаа нь агаарын бохирдол үүсгэх, цахилгаанаар шийдсэн тохиолдолд хэт өндөр ашиглалтын зардал гарч байна.



Төслийн зорилго

Энэхүү төслийн гол зорилго нь Ханбогд сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжийг төвийн төвлөрсөн дулаанаар хангаж, иргэдэд хямд зардлаар ая тухтай амьдрах орчин бүрдүүлэхэд оршино.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уурын зуухны барилга - 180м²- сэндвичин барилга

Халаалтын тогоо - 1.8мвт -3ш

Төслийн үр өгөөж

- Ханбогд суманд сүүлийн жилүүдэд баригдсан ЗДТГазрын барилга, соёлын төв, нийгмийн даатгал, цэцэрлэгийн барилга, 5 давхар орн сууцны барилга, иргэдийн хөгжлийн төв, малын эрүүл мэндийн нэгдсэн төв, сургууль цэцэрлэгийн цогцолбор барилга, прокурорын барилга зэрэг 9 томоохон барилга төвлөрсөн дулааны шугаманд холбогдоно.
- Бие даасан галлагааг багасгаснаар сумын төвийн агаарын бохирдол болон гал түймрийн аюул эрсдэлийг бууруулна
- Шинээр 7-с доошгүй ажлын байр бий болно

НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨСӨВ

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан: 350,000,000
төгрөг

Өмнөговь аймгийн ЗДТГ: 46,000,000 төгрөг



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Даланзадгад сумын 25 мянга гаруй иргэд
төслийн үр шимийг хүртэнэ.

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Даланзадгад сумын сүүлийн 5 жилийн албан ёсны бүртгэлтэй хүн амын тооны статистик мэдээг харахад жилд 1000 гаруй хүнээр тогтмол өссөн судлагаа гарсан байгаа бөгөөд 2017 онд 25 мянга гарсан байна. Дээрх хүн амын өсөлт, төвлөрлөөс шалтгаалан тус сумын суурьшлийн бүс нь өдрөөс өдөрт хүрээгээ тэлж төвөөсөө алслагдаж байгаа учир хот доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг зайлшгүй сайжруулах тулгамдсан асуудал болсон.



Төслийн зорилго

Төслийг хэрэгжүүлснээр Даланзадгад сумын төвийн нийтийн тээвэрт байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай эко автобусыг 5 чиглэлд явуулж алслагдсан гэр хорооллийн иргэд, хүүхдүүд ажил, сургуульдаа ирж, харихдаа хямд үнэтэй, автобусаар үйлчлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан дээрх автобусаар үнэ төлбөргүй үйлчлүүлэх, аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулах зэрэг эерэг үзүүлэлтүүд гарах юм.

Төслийн хүрээнд хийсэн ажил

- Даланзадгад суманд монгол инженерүүдийн зохион бүтээсэн 12 хүний сүүдалтай J-800EV-3 загварын 8 цахилгаан автобус нийлүүлнэ
- Ашиглалтын зааварчилгаа сургалт явуулна
- Монгол-GPS загварын байршил тогтоогч автобусанд суурилуулна
- Автобусанд мэдээллийн цахилгаан төлбөрийн тоног төхөөрөмж суурилуулна

Төслийн үр өгөөж

- Даланзадгад сумын төвийн гэр хооллын иргэд, хүүхдүүд ажил, сургуульдаа ирж, харихдаа хямд үнэтэй, ая тухтай автобусаар үйлчлүүлнэ
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээрх автобусаар үнэ төлбөргүй үйлчлүүлнэ
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ
- Аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулна

СУРГУУЛИЙН НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗАР БАРИХ



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ЗАХИАЛАГЧ: ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



ТӨСӨВ

39,650,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД


Ханбогд сумын ерөнхий боловсролын
сургуулийн 970 хүүхэд, 66 багш, ажилчид

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймгийн Ханбогд сумын 12 жилийн дунд сургуульд 950 гаруй хүүхэд суралцаж байгаа бөгөөд одоо ашиглаж байгаа сургуулийн барилга анх баригдахдаа багш, сургачдад зориулсан ариун цэврийн өрөөг шийдвэрлээгүй ба нийтийн бие засах газрыг зайлшгүй байгуулах нь сургуулийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Сурагчдын хувьд хичээлийн

завсарлагаанаар нийтийн бие засах зориулалтын орчин бүрдээгүйгээс гадаа урт дараалалд зогсох, сургуулийн орчинд ил бие засах, биеийн тавгүй байдалд байх, гар угаах, ариун цэврийн анхан шатны шаардлагыг хангаж чадахгүй байгаагаас элдэв халдварт өвчин гарах үр дагаврыг дагуулдаг. Эдгээр сөрөг нөхцлүүдийг багасгах, багш, сурагчдад соёлтой боловсон орчинг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу нийтийн бие засах газар байгуулах зайлшгүй нөхцөл шаардлага гарч байна.



Төслийн зорилго

Төслийг хэрэгжүүлснээр Ханбогд сумын ЕБС-ийн багш, сурагчдыг нийтийн бие засах газраар үйлчлүүлж соёлтой эрүүл орчинд, ая тухтай чирэгдэлгүйгээр ажиллаж, суралцах нөхцөл бүрдэх, зориулалтын бус ариун цэврийн байгууламжаас үүсэх элдэв халдварт өвчнийг бууруулах, багш, сурагчдыг цэвэр аюулгүй орчинд ажиллаж, сурах эрхийг хангах зэрэг эерэг үзүүлэлтүүд бий болно.

Төслийн хүрээнд хийсэн ажил

12х3,5м2 хэмжээтэй 9 тасалгаа бүхий зөөврийн, бүрэн тоноглогдсон, ариун цэврийн стандартын шаардлага хангасан нийтийн бие засах газрыг барина.

Төслийн үр өгөөж

- Стандартын бие засах газраар үйлчлүүлэн ариутгал, халдваргүйжилтийг бүрэн хийх боломжоор хангаснаар багш, ажилчид, сурагчдыг аливаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах, сурч боловсрох таатай нөхцөл бүрдэнэ
- Тус сургуульд шинээр 4 ажлын байр үүсч тодорхой ажилгүй иргэдийн өрхийн орлого нэмэгдэнэ
- Бусад сургуулиудад туршлага болно

ДАЛАНЗАДГАД СУМЫН ТӨВИЙН ХЭСГИЙН АВТОЗАМЫН ГАДАРГУУГИЙН УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ



**ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

ТӨСЛИЙН УДИРДЛАГА



**Говийн Оюу хөгжлийг дэмжих сан: 1,362,463,752
төгрөг**

ТӨСӨВ

Өмнөговь аймгийн ЗДТГ: 1,226,060,462 төгрөг



**Даланзадгад сумын 2, 3, 4, 7, 6 дугаар багийн ард
иргэд**

ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Бид хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөр Даланзадгад сумын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2030, сумын төвийн иргэдийг үерийн уснаас хамгаалах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан. Түүнчлэн сүүлийн жилүүдэд Даланзадгад сумын төвийн авто замууд нь ямарч үерийн ус зайуулах шугам сүлжээгүй баригдсанаас бороо орох бүрд авто замууд үерийн усанд шүүд автаж байгаа бөгөөд албан байгууллага, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд эрсдэл маш их үүсч байна.



Төслийн зорилго

Зам, талбайн үерийн ус зайлуулах шугам сүлжээг байгуулсанаар Даланзадгад сумын 2, 3, 4, 7, 6 дугаар багийн ард иргэдийг хаврын шар ус, зуны хур борооны үерийн усны хор хөнөөлөөс хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдруулах, их хэмжээний хөрөнгө оруулалтаар боссон иргэдийн үл хөдлөх хөрөнгө, гудамж, авто болон явган зам, хүүхдийн тоглоомын талбай, бетон талбайг хамгаалах нөхцөл бүрдэх юм.

Төслийн хүрээнд хийх ажил

Даланзадгад сумын төвийн хэсгийн 6.5км автозамын гадаргуугын ус зайлуулах шугамыг барина.

Төслийн үр өгөөж

- Даланзадгад сумын 2, 3, 4, 7, 6 дугаар багийн ард иргэдийг хаврын шар ус, зуны хур борооны үерийн усны хор хөнөөлөөс хамгаална
- Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ
- Авто зам, явган зам, хүүхдийн тоглоомын талбай болон иргэд албан байгууллагын үл хөдлөх хөрөнгө гэх мэт Даланзадгад сумын төвийн нийт бүтээн байгуулалтыг үер усны аюулаас хамгаална

2017 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БУЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР:

СЭВРЭЙ СУМЫН ГОВИЙН ТӨГӨЛ



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: НҮДЭН БУЛГИЙН ӨГӨӨЖ ХОРШОО



ТӨСӨВ

7,577,700 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Нүдэн булгийн өгөөж хоршооны шууд ашиг хүртэхээс гадна Өмнөговь аймгийн аялал жуулчлалын гол бүс нутагт байгаль экологийн эерэг нөлөө үзүүлнэ

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймгийн Сэврэй сумын Хонгорын голын элс нь уртаашаа 130 гаруй км үргэлжилсэн, газрын гадаргаас дээш 195 м өндөр, 3- 20 км өргөн их элсэн манхан бөгөөд Зөөлөн, Баян бор нурууны хоорондуур тогтсон, араар нь Хонгорын гол хэмээх 10 гаруй км үргэлжилсэн жижигхэн горхи бүхий үзэсгэлэнт тогтоцтой газар нутаг бөгөөд говийн

бүсийн аялал жуулчлалын гол бүс нутаг юм. Дээрх бүс нутгийн орчныг хамгаалж элсний нүүдлийг багасгах, цөлжилтийг бууруулах, аялал жуулчлалын таатай орчин нөхцөл бүрдүүлэх нэн шаардлагатай байгаа юм. Төсөл санаачлагчид нь 2013 оноос өөрсдийн боломжоор хашаа барих, мод суулгах, усны нөөцийн сав бэлтгэх зэрэг ажлыг өөрсдийн бололцоогоор ээлж дараалан хийсэн боловч орлого олдоггүй учир мод тарихад шаардлагатай бүх асуудлаа шийдвэрлэж чадаагүй, одоо усалгааны системтэй болох шаардлагатай байгаа юм.

Хөтөлбөрийн зорилго

Байгаль орчныг хамгаалж элсний нүүдлийг багасгах, цөлжилтийг бууруулах, аялал жуулчлалын таатай орчин нөхцөл бүрдүүлэхэд өөрсдийн хувь нэмрийг оруулж өөрийн суманд жишиг болохуйц төгөл байгуулах

Төслийн хүрээнд хийсэн ажил

Сэврэй суманд 5 га газарт 1000 мод услах усалгааны систем суурилуулсан.

Төслийн үр өгөөж

- Аялал жуулчлалын бүс нутагт ногоон байгууламж нэмэгдэж гадаад дотоодын аялагчдын аялах таатай орчин бүрдэх
- Байгаль орчиноо хамгаалж, элсний нүүдлийг багасгана
- 4-5 жилийн дараа сумын хэмжээнд жижиг болохуйц төгөл бий болно
- Говьд, элсний хажууд ЗАГ аас өөр төрлийн мод бут ургаж болдог, ач холбогдлыг хүмүүст сурталчлах
- Иргэд болон сургуулийн сурагчдад сурталчилгаа хийх
- Нүдэн булгийн өгөөж хоршооны 11 гишүүний гэр бүл шүүд ашиг хүртэнэ



ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ ЦЭМЦГЭР ДАЛАНЗАДГАД



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨСӨВ

40,500,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Даланзадгад сумын төвийн иргэд

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Даланзадгад сумын хог тээвэрлэх автомашины эд анги хуучирч, ашиглалтын хугацаа гүйцсэн зэргээс шалтгаалж эдийн засгийн хувьд үр ашиггүй үрэлгэн байдал бий болсон. Иймд бункер татан авч буулгах зориулалтын автомашин авах шаардлагатай болоод байна.

Хөтөлбөрийн зорилго

Хог хаягдлын тээвэрлэлтийн зориулалтын техник хэрэгсэл, тоног автомашинтай болж Даланзадгад хотынхоо хог хаягдлын асуудлыг шийдвэрлэнэ.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Даланзадгад суманд 3,8 тонн хаягдал зөөх тусгай тоноглолтой 1 автомашин нийлүүлсэн.

Төслийн үр өгөөж

- Хог хаягдлыг бункерээс хүрэдэж ачих явцад хог хаягдал хийсдэг байдал арилж зориулалтын автомашинаар зөөх бололцоотой болно.
- Хог хаягдал хуримтлагдахгүй.



**ДАЛАНЗАДГАД СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ
БОЛГОХ ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ,
ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ**



**ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

ТӨСЛИЙН УДИРДЛАГА



ТӨСӨВ

187,145,200 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Даланзадгад сумын төвийн 25000 иргэн

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

2017 оны байдлаар Даланзадгад сумын хүн амын тоо 2000 оныхоос даруй 1,98 дахин, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн нь 3,14 дахин байна. Гэтэл Даланзадгад сумын хог хаягдал цуглуулах, булах арга механизм, ажилчдын нөхцөл байдал, машин хангамж хүрэлцээ өөрчлөгдөөгүй тэр үеийн байдлаар үргэлжилсээр байна. Иймд хог хаягдлын менежментийн тогтсон хотын системтэй болохын тулд гадаад орны туршлагаас суралцах, дотоодын тэргүүн туршлагуудыг харьцуулах, мэргэжлийн үүднээс судалгаа хийх, шаардлагатай боловсон хүчин, машин механизм, барилга, байгууламжуудыг нэг бүрчлэн тооцоолох шаардлагатай байна.

Хөтөлбөрийн зорилго

Даланзадгад сумыг “БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, НОГООН, ХОГГҮЙ, ЖИШИГ ХОТ” болгоход хог хаягдлын менежментийн талаар баримтлах цогц баримт бичигтэй болно.

Төслийн хүрээнд хийсэн ажил

- Сумын хог хаягдлын менежментын тооцоо, судалгааны ажил, ТЭЗҮ боловсруулах
- Хог боловсруулах үйлдвэрийн барилгын зураг, төсөв боловсруулах
- Ажилчдын ажиллах болон амрах байрны зураг төсөв боловсруулах
- Хог зөөвөрлөх автомашины гаражийн барилгын зураг, төсөв боловсруулах
- Зуухны барилгын зураг, төсөв боловсруулах
- Гадна шугам сүлжээний зураг, төсөв боловсруулах ажил /Дулаан, цэвэр, бохир ус/

Төслийн үр өгөөж

- Ажлын зураг төсөл, менежментийн чиглэл мэргэжлийн түвшинд боловсруулагдана,
- Батлагдсан зураг төсөлтэй болно
- Даланзадгад сумын 25000 иргэд төслийн үр шимийг хүртэнэ



2017 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БУЙ НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР:

ИРЭЭДҮЙД ГЭРЭЛТЭХ НАС



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: МОНГОЛЫН ГЭР БҮЛИЙН САЙН
САЙХНЫ НИЙГЭМЛЭГИЙН ӨМНӨГОВЬ САЛБАР



ТӨСӨВ

63,271,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Ханбогд, Цогтцэций, Манлай, Баян-Овоо,
Гурвантэс, Ноён сум, Даланзадгад сумын нийт
250 ЕБСургуулийн сурагчид, нийгмийн ажилтан

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

2015 онд Өмнөговь аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварт өвчний 149 тохиолдол бүртгэгдсэн ба 2016 онд уг тоо 163 болж нэмэгдсэнээс 32,5%-ийг 19-аас доош насны охидууд эзэлж байгаа тул тэдний бэлгийн болон НҮЭМ эрх, БЗДХ-ын талаарх мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна.



Хөтөлбөрийн зорилго

Өсвөр үе, залуучуудын оролцоотойгоор эрүүл мэндийн клубуудын үйл ажиллагааг тогтворжуулж сургагч багш бэлтгэн бэлгийн болон НҮЭМ эрх, БЗДХ-ын талаарх мэдлэг, чадвар дадлыг эзэмшүүлэх сургалт явуулна.

Төслийн хүрээнд хийсэн ажил

-Үе тэнгийн сургагч багш бэлтгэх 6 удаагийн сургалт зохион байгуулж 12 сургуулийн 300 үе тэнгийн сургагч, зөвлөгч багшийг бэлтгэсэн. /14 удаагийн нөлөөллийн ажил, 1 удаагийн зуслангийн сургалт/

- Даланзадгад сумын 6 сургууль, Политехникийн коллеж, Гурвантэс, Ноён, Номгон, Баян-овоо, Цогтцэций, Манлай сумдын нийгмийн ажилтан, биологийн багш, сургуулийн эмч нийт 35 ажилтанг хамруулж бэлгийн болон НҮЭМ эрх, БЗДХ-ын талаарх мэдлэгийг сайжруулах, оролцоог нь нэмэгдүүлэх сургалт зохион байгуулсан

-Цаашид өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх идэвхжүүлэх санаачлагыг дэмжих цаашид хамтран ажиллах зорилгоор Эрүүл мэндийн газар, БСУГазар зэрэг 2 байгууллагад 3 үйлдэлтэй принтер авч өгсөн

- Төсөл хэрэгжсэн 13 сургуульд “Бидний сонголт эрүүл ирээдүй” мэдээллийн самбар хийж байршуулсан

Төслийн үр өгөөж

Ханбогд, Цогтцэций, Манлай, Баян-Овоо, Гурвантэс, Ноён болон Даланзадгад сумдын 14-17 насны хүүхэд залуучууд бэлгийн замын болон НҮЭМ эрх, БЗДХ-ын талаарх мэдлэгтэй болж өөрийгөө хамгаалж, урьдчилсан сэргийлж сурна

Ханбогд, Цогтцэций, Манлай, Баян-Овоо, Гурвантэс, Ноён сумдад тус бүр 25, Даланзадгад сумын 7 ЕБСургуулийн 80 сурагч мөн нийгмийн ажилтанг хамруулан нийт 250 сургагч багш бэлтгэнэ

ЦАХИМ БАГШ



ТӨСЛИЙН УДИРДЛАГА

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ : “ГОВИЙН ИРЭЭДҮЙ ТА”
НҮТББ



ТӨСӨВ

18,915,000 ТӨГРӨГ

Даланзадгад, Баяндалай, Баян-Овоо, Булган,
Хүрмэн, Ханхонгор, Номгон, Цогт-Овоо, Цогт-
Цэций зэрэг 9 сумын сургууль, цэцэрлэгийн 418
багш нар



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Төслийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймгийн сургууль цэцэрлэгүүд техник тоног төхөөрөмжөөр зохих хэмжээнд хангагдсан хэдий ч багш нарын шинэ тоног төхөөрөмж ашиглах, хичээлээ цахим хэлбэрээр явуулах мэдлэг, үр чадвар хангалтгүй түвшинд байдаг.



Хөтөлбөрийн зорилго

Сургууль, цэцэрлэгийн багш нарт цахим сургалтаар түвшний програм хангамжуудыг эзэмшүүлж, компьютер хэрэглэх үр чадвар олгох мэргэжлийн чадвар олгох

Төслийн хүрээнд хийсэн ажил

Даланзадгад, Баяндалай, Баян-Овоо, Булган, Хүрмэн, Ханхонгор, Номгон, Цогт-Овоо, Цогт-Цэций сумдын сургууль цэцэрлэгийн багш нарт цахим сургалт явуулах, мэргэжлийн түвшний програм хангамжуудыг эзэмшүүлэх, компьютер хэрэглэх үр чадвар олгож сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах сургалт явуулсан.

Төслийн үр өгөөж

- Бага ангийн 218 багш ажилтны мэдээлэл харилцааны технологийн боловсрол сайжирч сургалтын чанарт ахиц гарна
- Сургуулийн өмнөх боловсролын 200 багш, ажилтны мэдээлэл харилцааны технологийн боловсрол сайжирч сургалтын чанар сайжирна
- Багшийн хандлага, онолын мэдлэг, үр чадварыг сайжирна

2017 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГГИЖ БУЙ НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

ДАЛАНЗАДГАД СУМЫН 25-Р ЦЭЦЭРЛЭГИЙН STEAM ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: 25-р цэцэрлэг



ТӨСӨВ

6,450,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн 313
ХҮҮХЭД

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Даланзадгад сумын 25-р цэцэрлэг нь 2015 онд **Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн** хөрөнгө оруулалтаар баригдсан бөгөөд одоогийн байдлаар уг цэцэрлэгийн бэлтгэл, дунд, ахлах

бүлэгт 3-5 насны 313 хүүхэд сургуулийн өмнөх

боловсрол эзэмшиж байна. 25-р цэцэрлэгийн хамт олон

түвшингээ олон улсын стандартад хүргэх зорилгоор Германы Нобелийн шагналт Артур Фишерийн зохион бүтээсэн 50 гаруй жилийн түүхтэй “Steam” боловсролын шилдэг хөтөлбөрийг нэвтрүүлэх санаачлага 2017 онд гаргасан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь Өмнөговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын чанарыг дээшлүүлэхэд түлхэц болохуйц ажил болсон.



Хөтөлбөрийн зорилго

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 10 багш чадавхижж, 25-р цэцэрлэгийг 313 хүүхэд “Фишертип”-тархи хөгжүүлэх хичээлийн хөтөлбөр, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг ашиглан цэгцтэй ярьж, сэтгэж, бодож, дүрсэлж, зохион бүтээх чадвараа хөгжүүлэх юм.

Мөн Өмнөговь аймгийн хэмжээнд анх удаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бага насны хүүхдийн тархийг хөгжүүлэх хөтөлбөр нэвтрүүлэх юм.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн 10 багш “Steam brainy tech” ХХК-ийн явуулдаг сургалтанд хамрагдаж сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүнтэй танилцах, тооцоолол хийх, уг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх дадлага түршлага олж авсан бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн худалдан авч 8 сарын хугацаа буюу 2017-2018 оны хичээлийн жилд 25-р цэцэрлэгийн хүүхдүүдийг сургалтанд хамруулж байгаа. Хөтөлбөрийн эцэст хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг хэмжинэ.

Төслийн үр өгөөж

Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн 313 хүүхэд дүрслэх урлагийн тоглоомоор тоглож, байгалийн ухаан, технологи, инженерчлэл, матемакийн энгийн ойлголтуудыг интеграцилагдсан хэлбэрээр сурч, бүтээлч сэтгэлгээ, гарын эв дүйгээ хөгжүүлж, багаар ажиллах чадварт суралцана.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: Өмнөговь аймгийн
Хөдөлмөрийн, халамжийн үйлчилгээний газар

205,000,000 ТӨГРӨГ

Өмнөговь аймгийн нийт 163 эмэгтэй

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймгийн хэмжээнд иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг тогтоох, мөн ямар төрлийн ажлын байрыг илүүтэй сонирхдог талаар тандалт хийж нэгдсэн судалгаа явуулахад 4149 иргэн тодорхой

ажилгүй байгаа дүн гарсан. Эдгээр иргэдийн 66,25% нь хувиараа аж ахуй эрхлэн төсөл хөтөлбөрт хамрагдах сонирхолтой байгаа бол 33,7% нь тогтвортой ажлын байртай болохыг хүсч байна. Үүнээс 1843 нь буюу 43,8 хувь эмэгтэйчүүд байгаа нь ихэнх нь хүүхэд болон асаргаа шаардлагатай гэр бүлийн гишүүнээ асардаг, тохирох ажил олдохгүй байгаа гэх шалтгааны улмаас ажил эрхлэхгүй байна.



Хөтөлбөрийн зорилго

Ажил эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж Өмнөговь аймгийн нийт сумдаас 50 эмэгтэйг ажлын байртай болгож, 50 эмэгтэйг үр чадварын сургалтанд хамруулж тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Мэргэжлийн үнэмлэхтэй болгох сургалт зохион байгуулах
- Тоног төхөөрөмжийн тусламж үзүүлэх
- Борлуулалтын цэгээр дамжуулан бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ явуулах

Төслийн хүрээнд хийсэн ажил

Өмнөговь аймгийн хэмжээнд ажил үйлчилгээ эрхлэх хүсэлтэй эмэгтэйчүүдийн дунд төсөл боловсруулах сургалт явуулж төслийн уралдаан зарлаж 14 сумын эмэгтэйчүүдээс нийт 141 төслийн санал хүлээн авч 118 төслийн санал дэмжиж шаардлагатай үед тоног төхөөрөмжийн тусламж үзүүлсэн. Мөн “Бизнесээ эхэл, хөгжүүл” сэдэвт мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулсан.

Төслийн үр өгөөж

Хөтөлбөрийн хүрээнд 148 ажлын байр шинээр бий болж, 15 эмэгтэй тоног төхөөрөмжийн дэмжлэг авсан. Уг төслийн хүрээнд нийт 163 эмэгтэй хамрагдсан бөгөөд нийт хоёр зуун сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан.

БАГШИЙН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

ЗАХИАЛАГЧ: БОЛОВСРОЛ СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗАР

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ПОЛАРИС БОЛОВСРОЛЫН
АКАДЕМИ ХХК

150,000,000 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 160 БАГШ

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

2016-2017 оны статистик тоо мэдээг харвал Өмнөговь аймгийн нийт 27 сургуулийн өмнөх боловсролын 4806 хүүхдэд үйлчлэх 352, ерөнхий боловсролын нийт 11530 сурагчдад үйлчилэх 605 багш байна. Эдгээр багш нар ажил мэргэжлийн үр чадвараа дээшлүүлэх боломж хязгаарлагдмал байдаг нь мөн санал асуулгаар тогтоогдсон.



Хөтөлбөрийн зорилго

Өмнөговь аймгийн нийт сумдын 80 сургуулийн өмнөх болон 80 ерөнхий боловсролын сургуулийн багшийг 55 хоногийн цогц үр чадвар олгох сургалтанд хамруулах

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн боловсрол, соёл, урлагийн газраас нэр заасан нийт 160 багшийг 124 академик цагийн үр чадвар дээшлүүлэх сургалтанд хамруулсан. Уг хөтөлбөрт Даланзадгад сумын 16 багш, Цогтцэций сумын 14 багш, бусад 13 сумын тус бүр 10 багш сургалтанд сууж сертификаттай болсон.

Төслийн үр өгөөж

Өмнөговь аймгийн 160 багш Монголын уламжлалт заах арга барил, Уламжлал, шинэчлэлийг хослуулах, хувь хүний хөгжил, харилцааны үр чадвар, манлайлал, багаар ажиллах үр чадвар, ой тогтоолт, сэтгэхүй хөгжүүлэх, Англи хэл, Экологийн боловсрол, хүнсний аюулгүй байдлын тухай “Дадал олгон хэвшүүлэх” тусгай хөтөлбөрт хамрагдаж үр чадвараа дээшлүүлсэн.

МӨРӨӨДЛИЙН ЗҮГ ХАМТДАА ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР


ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ГОВИЙН ХҮҮ САН

34,695,000 ТӨГРӨГ

ДАЛАНЗАДГАД СУМЫН 3697 СУРАГЧ

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймгаас элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн ахлах ангийн төгсөгчдийн авсан дундаж оноо сүүлийн 8 жилд нийт аймгуудын дундаж онооноос ялимгүй доогуур байсан. Жишээ нь нийт аймгуудын элсэлтийн ерөнхий шалгалтанд авсан дундаж оноо 2014 онд 502,6, 2015 онд 498,5, 2016 онд 499,2 байсан бол Өмнөговь аймгийн хувьд тус онуудад харгалзан 497,1, 486,7, 499,8 байсан. Тиймээс Өмнөговь аймгийн ахлах сургууль төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтанд авдаг онооны түвшинг дээшлүүлэх шаардлагатай байгаа юм.



Хөтөлбөрийн зорилго

Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад арван төрлийн хичээлээр давтлага орж их дээд сургуульд амжилттай элсэн орж өөрийн хүсэл сонирхол, авьяас чадвартаа нийцэхүйц хэрэгцээтэй боловсролоо эзэмшихэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.


Төслийн хүрээнд хийсэн ажил

Хөтөлбөрийн хүрээнд аймгийн ахмад багш нарын холбооноос сонгогдсон багш нарыг урьж, Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 12-р ангийн сурагчдаас судалгаа авч хөтөлбөр зохион давхардсан тоогоор 797 сурагчийг сайн дурын үндсэн дээр бүрдүүлж элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлдэв. Мөн Даланзадгад сумын 9-12-р ангийн 1400 орчим сурагчдад “Амжилтанд хөтлөх-Амьдралын сонголт”, “Мөрөөдлийн менежмент” сэдвээр сургалт лекц зохион байгуулж, 1500 сурагчид мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөв.

Төслийн үр өгөөж

1400 сурагч сургалт, лекцэнд хамрагдаж, 1500 хүүхэд чиг баримжаа олгох зөвлөгөө авч, 797 төгсөх ангийн сурагч элсэлтийн ерөнхий шалгалт бэлдсэнээр хүүхэд тус бүр өөрт тохирох мэргэжлээ сонгож, цаашлаад хүссэн сургуульдаа ороход шаардагдах оноогоо авах мэдлэг, дадлага олж авсан.

ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ – ОЮУНЛАГ ЗАЛУУЧУУД ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ӨМНИЙНГОВИЙН ТҮҮЧЭЭ
ТББ

76,355,400 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 160 БАГШ

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийн хэлтэст бүртгэлтэй ажил хайгч 865 иргэний 531 нь буюу 61% -ийг 15-35 насны залуучууд эзэлж байгаа бол аймгийн хэмжээнд 2016 онд гэмт хэрэгт 448 хүн холбогдсны 61%-ийг энэ насны залуус эзэлж байна. 2016 оны 10 сарын

байдлаар бэлгийн замаар дамжих халдвар 184 бүртгэгдсэнээс 162 буюу 88%-ийг 15-35 насны залуучууд эзэлж байна. Залуучуудын хөгжлийг дэмжих хууль 2017 оны 05 сард УИХ-аар батлагдаж залуучуудын эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжих тусгайлсан хуультай болсон тул дээрх асуудлуудыг хууль эрх зүйн түвшинд шийдвэрлэж болохоор болж байна.



Хөтөлбөрийн зорилго

Өмнөговь аймгийн 15 сумын залуучуудад залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн талаарх мэдлэг ойлголт өгч, залуучуудын нийгмийн амьдралд оролцох бодитой, утга учиртай оролцоонд ахиц гаргана.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулав.

- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль сурталчлах “Бид хуультай боллоо” арга хэмжээ
- Өмнөговь аймгийн Залуучуудын урлаг спортын анхдугаар их наадам
- Бид баялагийг оюунаараа бүтээнэ залуучуудын уулзалт, зөвлөгөөн
- Шилдэг залуучуудыг гадаадад туршлага судлуулах үйл ажиллагаа

Төслийн үр өгөөж

- “Бид хуультай боллоо” арга хэмжээ болон Бид баялагийг оюунаараа бүтээнэ залуучуудын уулзалт, зөвлөгөөнд шинээр батлагдсан хуулийг танилцуулах зорилгоор 2000 гаруй тараах материал хэвлүүлж тараасан бөгөөд 10,000 залуучуудад хуулийн тухай мэдлэг түгээсэн
- Өмнөговь аймгийн Залуучуудын урлаг спортын анхдугаар их наадамд 16-35 насны 800 гаруй тамирчид оролцсон
- Үе тэнгийнхнийхээ манлайлал болсон шилдэг 10 залуучуудыг БНХАУ-д туршлага судлуулах үйл ажиллагаанд хамруулсан.

АХМАДУУДАД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,
ТЭГШ ДҮҮРЭН ЭМНЭЛЭГ

76,903,416 ТӨГРӨГ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 4400 АХМАД
НАСТАН

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Өмнөговь аймаг нь нийт 63,661 хүн амтай бөгөөд нийт хүн амын 11,3% буюу 7193 нь ахмад настан байна. 2016 оны байдлаар хөдөөгийн 14 суманд 2394, Даланзадгад суманд 4799 ахмад настан байна.

Тэдгээрээс өвчний үлмээс 2301 ахмад буюу 31.9% нь эмнэлгийн идэвхтэй хяналтанд эмчлүүлж байна. Өндөр настны өвчний

голлох шалтгаанууд нь зүрх судасны эмгэг-26.6%, хоол боловсруулах замын эмгэг 11.2%, чихний эмгэг-10.6%, хавдар-6%, яс булчин, үе мөчний эмгэг-10,3% байна.



Хөтөлбөрийн зорилго

(IV бүлгийн өвчлөлтэй хүн – Хагас ээнэгшил бүхий архаг өвчтэй хүмүүс, V бүлгийн өвчлөлтэй хүн – Ээнэгшлээ алдсан архаг өвчтэй хүмүүс)-ийг эрүүл мэндийн үзлэг оношлогоо, идэвхитэй хяналтанд оруулах

Төслийн хүрээнд хийсэн ажил

Хөтөлбөрийн хүрээнд 4 төрлийн 6000 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлэн тарааж, 3000 ширхэг судалгааны асуумж бэлтгэн ахмад настнуудаас /55-аас дээш настай эмэгтэй, 60-аас дээш настай эрэгтэй ахмадыг судалгаанд хамруулсан. /судалгаа авч уг судалгааны үр дүнд үндэслэн мэдээллийн сан бүрдүүлсэн. Өмнөговь аймгийн 14 сумын 6454, Даланзадгад сумын 2048, нийт 8502 ахмад настанг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж 4, 5-р бүлгийн өвчлөлтэй 650 ахмад настнуудын Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Төв, Сум дундын эмнэлэг болон Эрүүл мэндийн төлүүдэд идэвхитэй хяналтанд оруулсан.

Төслийн үр өгөөж

Аймгийн 15 сумын 55-аас дээш насны ахмадаас давхардсан тоогоор нийт 8502 ахмад настанг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, өвчнийг эрт үед нь илрүүлж, цаашдын хүндрэлээс сэргийлэх, түүнчлэн сэргийлж болох нас баралтыг бууруулах /сохрол, харвалт, зүрхний шигдээс, хавдар, тэнэгрэл/, 4-5-р бүлгийн ахмад настанг идэвхтэй хяналтанд оруулж, ахмад настны үйлчилгээг сайжруулахад салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн. Бүх сумдын хэвтрийн байнгын асаргаа, сувилгаатай 67 ахмадад гэрээр нь очиж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор нь хүргэсэн. Өмнөговь аймгийн 23 эрүүл мэндийн байгууллагын 75 эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулсан.

МАНЛАЙ СУМЫН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН КАБИНЕТ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

ЗАХИАЛАГЧ: МАНЛАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ЭЛСНИЙ ХҮЧ ХХК

24,789,050 ТӨГРӨГ

МАНЛАЙ СУМЫН СУРГУУЛИЙН 125
СУРАГЧ

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Мэдээлэл харилцааны технологи хурдацтай хөгжиж байгаа энэ үетэй сумын сургуулиудын сурагчдыг хөл нийлүүлэн алхуулах нөөц бололцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна. Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд нийт 325 сурагч суралцаж байгаа бөгөөд 13 ажилчин, 3 удирдлага гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Уг сургуулийн стандарт хангалт 98.3%, чанар 31,4%-тай байгаа ба энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр стандарт хангалт 100%, чанар 41-45%-д хүрэх боломжтой.



Хөтөлбөрийн зорилго

Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд мэдээлэл технологийн кабинет байгуулж тохижуулан 6-9-р ангийн 125 сурагч, ажилчдад компьютерийн мэдлэг олгож интернет орчинд ажиллаж сургана.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч нь Манлай сумын ЗДТГ-ын захиалгаар 79 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авч Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд хүлээлгэн өгсөн.

Төслийн үр өгөөж

Уг төслийг хэрэгжүүлснээр Манлай сумын ерөнхий боловсролын сургалтын түвшин, чанар сайжирч сурагчдын өрсөлдөх чадвар сайжирч багш, ажилчдын компьютерийн хэрэглээний чадвар ихэсч сургалтын чанар сайжирна.

МАНЛАЙ СУМЫН ДИЗАЙН ТЕХНОЛОГИЙН КАБИНЕТ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

**ЗАХИАЛАГЧ: МАНЛАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ОЧИР ЭНЕРГИ ХХК

10,998,483 ТӨГРӨГ

**МАНЛАЙ СУМЫН СУРГУУЛИЙН 69
СУРАГЧ**



Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага

Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд 325 сургагч суралцаж байгаагаас 6-9 дүгээр ангийн 69 эрэгтэй сурагч суралцаж байна.

Хөтөлбөрийн зорилго

Манлай сумын ерөнхий оловсролын сургуульд дизайн технологийн кабинет байгуулж уг сургуулийн сурагчдын мэдлэг чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангана

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч нь Манлай сумын ЗДТГ-ын захиалгаар 36 нэр төрлийн 270 ширхэг тоног төхөөрөмж худалдан авч Манлай сумын ерөнхий боловсролын сургуульд хүлээлгэн өгсөн.

Төслийн үр өгөөж

Манлай сумын ерөнхий боловсролын сургуулийн чанар сайжирч, орчин үеийн стандартад нийцсэн сургалтын орчин бүрдэж сурагчдын танин мэдэхүй, урлан бүтээх чадвар, мөн тэдгээрийн идэвх оролцоо нэмэгдэнэ.

2017 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГГИЖ БУЙ УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭРИЙН
МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

ШИЛМЭЛ СҮРЭГ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗАР



ТӨСӨВ

138,828,840 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Булган, Сэврэй, Мандал-Овоо, Ханбогд
сумын 154 малчин өрх үр шим хүртэнэ

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Өмнөговь аймаг нь нэгж малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор судалгаа, шинжилгээний нөр их ажлын үр дүнд “Говь гурван сайхан” ноолуурын ямааг 1971, сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд судалсны үндсэн дээр 2016 онд “Галбын улаан” “Ханын хэцийн хүрэн” тэмээг үүлдэр болгон батлуулсан онд мал хувьчлалын ажил явагдаж Говийн бүсийн бэлчээрийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, “ГГС” ямааны улсын үржлийн ферм татан буугдсанаас хойш үржил селекц, ангилалтын ажил хийгдээгүй бөгөөд энэхүү гурван үүлдрийн малын ашиг шимийг тооцох, хувьслын ангилалт хийх зайлшгүй шаардлага болсон.



Хөтөлбөрийн зорилго

Өмнөговь аймгийн бренд болсон Говь Гурван сайхан үүлдрийн ямаа, Ханын хэцийн хүрэн, Галбын говийн улаан үүлдрийн тэмээний үржил, селекц, ангилалтын ажлыг хийж, үржлийн стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж, цөм сүрэг бий болгож ажиллана.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд Булган, Сэврэй сумдын Говь Гурван Сайхан ямааны үндсэн сүргийг малладаг 118 малчин өрхийн 15503, цөм сүргийн 180, нийт 15683 толгой бүхий нас насны хээлтэгч, хээлтүүлэгч ямаанд хаврын ангилалт хийж ээмэгжүүлэн журналд бичилт хийн бүртгэлжүүлсэн. Хээлтэгч, хээлтүүлэгч нийт 99 ямаанд хяналтын самналт хийж гарцыг тодорхойлсон. Булган, Сэврэй сумдын 125 ямаанаас дээж авч ноос ноолуурын задлан шинжилгээнд оруулсан. Ханбогд сумын 15 өрхийн 458 хээлтэгч, хээлтүүлэгч тэмээнд жинлэлт хийж ээмэглэн ангилалтын журналд бүртгэсэн. Мандал-Овоо сумын 10 өрхийн 465 тэмээнд жинлэлт хийж ээмэглэн үржлийн бүртгэлд бүртгэсэн. Хаврын хэмжилтийн ажлын боловсруулалтаар үүлдрийн стандартад нийцсэн нийт 4 үхна, 133 зусаг, 337 эм ямаа худалдан авч гэрээт малчдаар маллуулж байгаа.

Төслийн үр өгөөж

Өмнөговь аймгийн “Говь Гурван сайхан” үүлдрийн ямаа, “Ханын хэцийн хүрэн”, “Галбын говийн улаан” үүлдрийг хамгаалах ажил хийж Булган, Сэврэй, Ханбогд, Мандал-Овоо сумын 17,753 малд ангилалт, жинлэлт, самналт, ээмэгжүүлэх ажил хийж, **154 өрхийн 474 малыг худалдан авч цөм сүрэг бий болгосон.**

БЭЛЧЭЭР ЭРДЭНЭ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗАР



ТӨСӨВ

320,000,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Ханбогд, Баян-Овоо, Баяндалай, Цогт-Овоо
сумдын 377 малчин үр шим хүртэнэ



Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 11072,3 мянган га буюу 67 хувийг бэлчээрийн газар эзэлж, өнгөрсөн оноос 285,5 га-гаар бэлчээрийн газар бүүрч, 7 сумын 1069,6 мянган га бэлчээр уул уурхайн ашиглалт, зам тээвэрлэлтийн явцад доройтож, ургац 0,2 цн/га хүртэл буурсан, нийт бэлчээрийн 27,9 хувь нь буюу 3064,7 мянган га бэлчээр доройтолд орсныг 2010 оны хянан баталгаагаар тогтоосон бөгөөд түүнээс хойш бэлчээрийн төлөв байдлын хянан баталгаа хийгээгүй.

Хөтөлбөрийн зорилго

Ханбогд, Баян-Овоо, Баяндалай, Цогт-Овоо сумын малчдыг бүлгийн зохион байгуулалтанд оруулж бэлчээр эзэмшүүлэн бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, нөөцийг тогтоох, нутгийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хяналт, тогтолцоог сайжруулах ажил хийнэ.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг төслийн хүрээнд Ханбогд суманд-4, Баян-Овоо суманд-14, Баяндалай суманд-4, Цогт-Овоо суманд-4, нийт 26 малчдын бүлэг байгуулж зохион байгуулалтанд оруулж дүрэм батлуулан ажиллаж байна. Зорилтот сумдад тус бүр 1-3 удаагийн сургалт явуулж 377 малчинд бэлчээрийн даац, нөөцийн тухай мэдээлэл хийж нийт 10 га газар хашсан байгаа. Мөн уг сумдад 71 цэгт бэлчээрийн нөөц судлах баг ажиллаж судалгаа хийж байгаа бөгөөд шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж байгаа.

Төслийн үр өгөөж

Уг хөтөлбөр хэрэгжсэнээр Ханбогд, Баян-Овоо, Баяндалай, Цогт-Овоо сумдын малчид бэлчээрийн даац, нөөц, хэрхэн зүй зохистой ашиглах тухай мэдээлэлтэй болж малчдын бүлгийн зохион байгуулалтанд орсноор хамтран бие биенээ дэмжиж, бэлчээрээ зүй зохистой ашиглаж сурах бөгөөд бэлчээрийн даац, нөөцийн нэгдсэн зураглалтай болно.

2017 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГГИЖ БУЙ ҮНДЭСНИЙ ТҮҮХ СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨТӨЛБӨРҮҮД

**ТҮҮХ СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТЫГ
САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР**



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ
УРЛАГИЙН ГАЗАР**



ТӨСӨВ

80,000,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

**Баяндалай, Булган, Баян-Овоо, Гурвантэс,
Мандал-Овоо, Манлай, Ноён, Номгон,
Ханбогд, Сэврэй сумын 107 гэрээт хамгаалагч**

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Түүх соёлын үл хөдлөх дурсгалууд байгаль цаг агаарын нөлөө болон хүний зохисгүй үйл ажиллагаанаас болж элэгдэн гэмтэж, хагарч бутран анхны хэлбэр төрхөө алдсаар байна. Тиймээс

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Засгийн газрын 2018 оны 175 дугаар тогтоолоор баталсан улс аймгийн хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх газруудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.



Хөтөлбөрийн зорилго

Баяндалай, Булган, Баян-Овоо, Гурвантэс, Мандал-Овоо, Манлай, Ноён, Номгон, Ханбогд сумын нутаг дэвсгэр дэх улс аймгийн хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх газруудыг хамгаалж гэрээт хамгаалагчдад хариуцуулах

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт” нэртэй 2 бүлэг, 7 дэд сэдэвтэй гарын авлага боловсруулан хэвлүүлсэн бөгөөд “Өмнөговь аймаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт, цаашид анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг аймгийн хэмжээнд бүртгэлтэй 107 гэрээт хамгаалагч, иргэд, сум багийн Засаг дарга, Соёлын твийн соёлын өв хариуцсан ажилтан, нийт 160 хүнийг хамруулсан анхдугаар уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Төслийн үр өгөөж

Өмнөговь аймгийн 14 сумын 107 гэрээт хамгаалагч иргэн, 15 сумын Засаг дарга, 39 багийн Засаг Дарга, 18 соёлын төвийн ажилтан, нийт 179 хүнд соёлын өвийг хамгаалах хууль, эрх зүйн орчин, археологи, палеонтологи, түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар мэдээлэл өгсөн. Зөвлөгөөний үеэр үл хөдлөх дурсгалын хууль бус малтлага, тоннуулыг бүртгэн баримтжуулах, холбогдох харьяа байгууллагад цаг алдалгүй үнэн бодит мэдээллийг дамжуулах зорилгоор аймгийн хэмжээнд бүртгэлтэй 107 гэрээт хамгаалагчдад бага оврын дижитал аппарат олгож гэрээт хамгаалагчдыг идэвхжүүлсэн.

ЗАН ЗАНШИЛ-СУРГАЛТ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ХАНБОГД СУМЫН БАГА СУРГУУЛЬ



ТӨСӨВ

36,220,000 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

Ханбогд сумын бага сургуулийн 950 гаруй
сурагчид үр шимийг хүртэнэ

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг тоглож байгаа тоглоомоор нь шинждэг ёсон байдаг. Одоогийн үед бага насны хүүхдүүд шагайгаар наадах, эвлүүлдэг тоглоомуудаар тоглох нь эрс

Эцэг өвөгдөөс уламжлан ирсэн түүхэн соёлоо мартаггүйгээр хүүхэд багачууддаа өвлүүлж үлдээх нь эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч бидний хийж чадах маш том үйл хэрэг юм.



Хөтөлбөрийн зорилго

Ханбогд сумын бага сургуульд зан заншлын кабинет байгуулж тохижуулан зан заншил, өв соёлын тухай мэдлэг олгох хичээлийн баазтай болно.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд зан заншлын кабинет байгуулж 466 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, ном, тоглоом нийлүүлж тохижуулсан бөгөөд бага сургуулийн хүүхдүүд багш нартайгаа хамтран сургуулийнхаа хашаанд 650 хайлаас тарьж ургуулсан. Одоогийн байдлаар нэг удаад 25-30 хүүхэд зан заншлын сургалт авч байна.

Төслийн үр өгөөж

Хөтөлбөр хэрэгжсэнээр 950 гаруй бага сургуулийн сурагч мэдлэг оюунаа тэлж, өв соёл, үндэсний уламжлалт тоглоом наадгайгаар тоглож сэтгэхүйгээ хөгжүүлэх бололцоо бүрдүүлж зориулалтын дагуу хүүхэд багачуудыг хамруулсан. Уг хичээлийн хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүд мэндлэх, хүндлэх ёс, харилцааны соёл, байгаль орчинтой зөв харьцахад суралцсан.

ЗӨӨЛӨН САНДАЛ, МЭРГЭЖЛИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА



ТӨСӨВ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

**ХӨТӨЛБӨРИЙН ЗАХИАЛАГЧ: ХАНБОГД
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**


**ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭГЧ: МОНТЕЛ
ХХК**

149,800,000 ТӨГРӨГ

**Ханбогд сумын соёлын төвийн 8 ажилчин үр
шимийг хүртэнэ**

Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Ханбогд суманд 2016 онд шинээр 320 суудалтай “Үлэмжийн чанар” соёлын төв баригдсан бөгөөд уг соёлын төвийг тохижуулах ажил байсан. Тиймээс шаардлагатай болон сандал нийлүүлж Ханбогд сумын иргэдийг соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцох боломжийг бий болгох хэрэгцээ үүссэн.



Хөтөлбөрийн зорилго

Ханбогд сумын иргэд, дамжин өнгөрөх зочдыг тав тухтай орчинд хүлээн авах зорилгоор Үлэмжийн чанар соёлын төвд зориулалтын тоног төхөөрөмж, сандал нийлүүлнэ.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Ханбогд сумын соёлын төвд 320 сандал, 63 төрлийн гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж нийлүүлж соёлын төвийн ажилчдад 16 цагийн сургалт явуулсан.

Төслийн үр өгөөж

Соёлын төвд шаардлагатай гэрэлтүүлэг, үзэгчдийн сандал нийлүүлүүснээр Ханбогд сумын уургуул 6600, суугуул 13000 хүн амд соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх ая тухтай орчин нөхцөл бүрдсэн.

ХӨДӨӨГИЙН СОЁЛ-ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ ХӨТӨЛБӨР



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

ХӨТӨЛБӨРИЙН ЗАХИАЛАГЧ: МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ТӨСӨВ

**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ХАЙРХАН БАЯН БОР ХХК**

21,015,600 ТӨГРӨГ



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

**Мандал-Овоо сумын соёлын төвийн 32
ажилчин**



Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Хөдөө орон нутгийн соёлын үйл ажиллагаа сайн байх нь иргэдэд түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулж иргэдийг өргөнөөр хамруулах боломж олгодог. Гэвч өнөөгийн байдлаар төсвийн байгууллагын санхүүжилтээр санхүүжүүлэх нөхцөл боломж хомс байгаа тул техник тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлээр хангах боломжгүйд хүрсэн.

Хөтөлбөрийн зорилго

Мандал-Овоо сумын соёлын төвд орчин үеийн тайзны гэрэлтүүлэг, өнгө үзэмж сайтай хувцас хэрэглэл нийлүүлж үзэгчдийн таашаалд нийцсэн урлаг, уран бүтээлийг толилуулж, ардын авъяасыг дэмжих ажил хийх юм.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд Мандал –Овоо сумын соёлын төвд 50 төрлийн хувцас хэрэглэл, 23 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.

Төслийн үр өгөөж

Уг хөтөлбөр хэрэгжсэнээр Мандал-Овоо сумын соёлын төвийг 32 тоглолтын хувцас хэрэглэл, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд урлаг соёлын олон талт үйл арга хэмжээ тогтмол, чанартай хүргэснээр Мандал-Овоо сумын төв болон хөдөөгийн нийт 1628 хүн ам үр шимийг нь хүртэнэ.

ОРОН НУТГИЙН БИЗНЕС ХӨГЖИЛ ЧИГЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЗАДГАД СУМАНД ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙН
ЦОГЦОЛБОР ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**



ХӨТӨЛБӨР УДИРДЛАГА

**ХӨТӨЛБӨРИЙН ЗАХИАЛАГЧ: ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**



ТӨСӨВ

**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
ХОЛИМОГ СУРГАЛТ ИНСТИТУТ ТББ
ГОВИЙН ОЮУ ХДС-199,578,400 ТӨГРӨГ**



ҮР ШИМ ХҮРТЭГЧИД

БУСАД ЭХ ҮҮСВЭР-43,800,000 ТӨГРӨГ
Өмнөговь аймгийн хөдөө аж ахуйн 4
мэргэжилтнүүд болон 200 ногоочин,
агрономчид



Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Өмнөговь аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар жилд дунджаар 800 өрхийн 1000 гаруй ногоочид 200 орчим га талбайд төмс жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал тариалж байгаа бөгөөд хүн орчим хүнсний ногоо, жимс жимсгэнэ 0,1 хувийг дөнгөж хангаж байна. Тиймээс Өмнөговь аймгийн хүлэмжийн тариаланг дэмжих цогц бодлого хэрэгжүүлж, говийн бүсэд тохиромжтой усалгааны системийг судлах, хөгжлийн боломжийг тооцох зайлшгүй шаардлагатай байна.

Хөтөлбөрийн зорилго

Өмнөговь аймгийн цаг уур, хөрсний онцлогт тохирсон газар тариалагийн технологийг боловсруулан сургалтаар түгээх замаар аж ахуй нэгж болон өрхийн тариалан эрхлэгчдийг чадавхжуулан Өмнөговь аймгийн хэмжээнд газар тариалангийн гол бүс болох Даланзадгад, Булган, Сэврэй, Ноён сумдад хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалтыг хөгжүүлнэ.

Төслийн хүрээнд хийсэн ажил

Уг хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн цогцолбор хөгжүүлэх газарт байрзүйн зураглалын ажил хийж хөрсний чанар болон физик химийн үзүүлэлтийг хөрснөөс дээж авч лабораторийн шинжилгээнд явуулж хөрсний агрохимийн шинж чанарыг тодорхойлж мэдээллийн сан үүсгэн тохиромжтой усалгааны системийн туршилт тохируулгын ажил хийв. 5 нийлэг хальсан хүлэмж усалгааны системийн хамт суурилүүлж, туршилтын талбайд 1га газарт хүнсний ногооны үр үржүүлгийн туршилтын ажил хийсэн. Харин лооль, хэмх, гүзээлзгэнэ, тавас болон хулууг 1500 метр талбайд тарьж ургуулан туршилт хийв. Мөн Өмнөговь аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, Өмнөговь аймгийн ЗДТГ-ын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнсанбүк аймгийн хүнс хөдөө аж ахуйн технологийн хүрээлэнгээс туршлага солилцох ажилд хамрагдаад байна.

Төслийн үр өгөөж




Өмнөговь аймагт 3 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор сумдын 200 агрономчид, ногоочдыг хамруулж мэдээлэл өгсөн. Даланзадгад суманд хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх эхлэл тавигдаж байрзүйн зураглалын сүлжээтэй болж хөрсний судалгаа хийгдсэн байна.

2017 онд батлагдсан нийгмийн суурь үйлчилгээний чиглэлийн дараах хөтөлбөрүүд тендерийн үе шатанд байгаа. Үүнд:

№	Хөтөлбөрийн нэр	Зорилтот газар	Захиалагч	Хөтөлбөрийн агуулга	Хүрэх үр дүн
1	Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багаж тоног төхөөрөмжийн хүрэлцээнд нөлөөлөх нь	Өмнөговь аймаг болон Говийн бүсийн иргэд	Х.Шаравын нэрэмжит Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв	Өмнөговь аймгийн хэмжээнд эх хүүхдийн эрүүл мэндийн талаар үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна	БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн мэс заслын ком багаж хэрэгслийг сольж 24 төрлийн багаж тоног төхөөрөмж нийлүүлнэ
2	БОЭТ-ийн шүдний кабинетийг тохижуулах төсөл	Өмнөговь аймаг болон Говийн бүсийн иргэд	Х.Шаравын нэрэмжит Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв	Х. Шаравын нэрэмжит БОЭТ-ийн шүдний кабинетэд ажиллах эмч мэргэжилтэн бэлтгэж, багаж тоног төхөөрөмж, эм материалаар хангана	2 шүдний эмч, 3 сувилагчийг ажлын байраар хангаж 76 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангана
3	Аюулгүй хашаа	Даланзадгад сумын 4-р сургууль	Даланзадгад сумын 4-р сургууль	4-р сургуулийн гадна хашааг засаж сайжруулна	4-р сургуулийг тойруулан 900 гаруй метрийн аюулгүй байдалд эерэгээр нөлөөлөх стандартад нийцсэн хашаа барина
4	Ахмал настанд ээлтэй орчин	Өмнөговь аймгийн нийт сум	Өмнөговь аймгийн Нийгмийн халамжийн хэлтэс	Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын хээрийн болон төвийн сувилалыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ахмадуудад зориулсан таатай орчин, нөхцлийг бүрдүүлнэ	Ахмадын сувилалд 17 төрлийн 29 багаж тоног төхөөрөмж нийлүүлж, сувилалын гадна тохижилтын ажил хийнэ
5	Зөвлөх профессоруудын баг	Өмнөговь аймгийн нийт сум	Өмнөговь аймгийн ЗДТГ	Улсын томоохон эмнэлэг, төв, их сургуулийн профессор, эмч нарыг урьж 56 хоногийн турш Өмнөговь аймгийн эмч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулна	Өмнөговь аймгийн сум, баг, өрхийн нийт 126 эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж арга зүйн зөвлөгөө өгнө

6	Өмнөговь аймагт 2020 он хүртэл яаралтай болон мэс заслын тусламжийг чадавхжуулах төсөл	Өмнөговь аймаг болон Говийн бүсийн иргэд	Х.Шаравын нэрэмжит Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв	Х.Шаравын нэрэмжит БОЭТ-ийн чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлнэ	Х.Шаравын нэрэмжит БОЭТ-ийн яаралтай тусламж болон мэс заслын тусламж үйлчилгээнд шаардлагатай 41 багаж тоног төхөөрөмж нийлүүлнэ
---	--	--	---	---	---

САНГИЙН 2017 ОНЫ ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Хөрөнгө	0.00	0.00
Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,768,726,191.30	8,479,802,018.23
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,768,726,191.30	8,479,802,018.23
Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	14,359,970.00	64,508,260.00
Үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	2,480,771.00	8,108,395.83
Биет бус хөрөнгө	0.00	1,790,000.00
Биет бус хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	0.00	134,306.56
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,879,199.00	58,055,557.61
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,780,605,390.30	8,537,857,575.84
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	0.00	0.00
Дансны өглөг	0.00	2,723,135,573.00
Цалингийн өглөг	0.00	180.00
Татвар, хураамжийн өглөг	0.00	505,809.00
Богино хугацаат өглөгийн дүн	0.00	2,723,641,562.00
Өр төлбөрийн нийт дүн	0.00	2,723,641,562.00
Цэвэр хөрөнгө	0.00	0.00
Хуримтлагдсан үр дүн	6,780,605,390.30	5,814,216,013.84
Цэвэр хөрөнгийн дүн	6,780,605,390.30	5,814,216,013.84
Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн	6,780,605,390.30	8,537,857,575.84

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

		<i>(төгрөгөөр)</i>	
Үзүүлэлт		Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		974,861,071.8	974,861,071.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		0.	0.
Залруулсан үлдэгдэл		0.	0.
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт		0.	0.
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт		0.	0.
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		0.	0.
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		0.	0.
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		5,805,744,318.5	5,805,744,318.5
		0.	0.
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		0.	0.
Залруулсан үлдэгдэл		0.	0.
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт		0.	0.
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт		0.	0.
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		0.	0.
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		0.	0.
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		-966,389,376.46	-966,389,376.46
		0.	0.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны орлого	0.00	0.00
Бэлэг, хандив, тусламжийн орлого	10,024,900,000.00	12,024,650,000.00
Бусад орлого	0.00	33,462,930.00
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	10,024,900,000.00	12,024,650,000.00
Үндсэн үйл ажиллагааны зардал	0.00	0.00
Бэлэг, хандив ба тусламж	0.00	368,125,762.00
Байгууллагад өгсөн хандив, тусламж	0.00	368,125,762.00
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	0.00	112,982,902.00
Төсөл хэрэгжүүлсний зардал	4,051,415,424.00	12,100,935,013.00
Ерөнхий удирдлагын зардал	167,740,257.50	442,458,629.46
Цалин хөлс, шагнал	63,171,397.00	142,802,389.00
Нийгмийн даатгалын шимтгэл	6,948,853.50	15,919,467.01
Засвар үйлчилгээний зардал	635,000.00	115,000.00
Ашиглалтын зардал	9,376,631.00	12,745,715.00
Түрээсийн зардал	14,850,000.00	14,850,000.00
Тээврийн зардал	91,600.00	7,780,370.00
Элэгдлийн зардал	2,480,771.00	5,761,931.39
Зар сурталчилгааны зардал	23,097,960.00	66,679,620.00
Шуудан, холбооны зардал	2,255,047.00	3,698,431.06
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	4,219,155,681.50	13,024,502,306.46
Үндсэн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,805,744,318.50	-999,852,306.46
Тайлант үеийн цэвэр үр дүн	5,805,744,318.50	-999,852,306.46

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Үйл ажиллагааны мөнгөн орлого	10,032,000,000.00	12,029,569,184.00
Бэлэг, хандив, тусламж	10,024,900,000.00	12,006,650,000.00
Бусад	7,100,000.00	22,919,184.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлага (-)	4,223,774,910.50	10,284,555,067.07
Ажиллагчдад олгосон мөнгө	63,171,397.00	133,104,801.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,948,853.50	26,147,527.01
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	75,030,958.00	61,226,489.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	27,116,678.00	31,380,394.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	91,600.00	9,496,380.00
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	4,051,415,424.00	10,021,295,514.06
Төлсөн татвар	0.00	1,807,437.00
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	0.00	96,525.00
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	5,808,225,089.50	1,745,014,116.93
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	13,664,970.00	33,938,290.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-13,664,970.00	-33,938,290.00
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,794,560,119.50	1,711,075,826.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	974,166,071.80	6,768,726,191.30
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,768,726,191.30	8,479,802,018.23

САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧДИЙН СЭТГЭГДЭЛ

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Төслийн үр шим хүртэгчийн нэр: А.Дэлгэрэх

Сэтгэгдэл:

Миний бие 2017 онд Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас санаачилан Говийн Оюу хөгжлийг дэмжих сангаас санхүүжүүлэгдэн хэрэгжсэн Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан 1,500,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан.

Би сонирхлоороо хувиараа оёдол хийдэг бөгөөд тус хөтөлбөрт хамрагдан авсан санхүүжилтээрээ шулуун оёдлын машин, бараа материал, хэрээсний машин болон бусад туслах материал авч үйлдвэрлэлээ өргөтгөн оёдлын үйлвэр байгуулан 3 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байгаадаа баяртай байна.



Төслийн үр шим хүртэгчийн нэр: Ц.Ууганцэцэг

Сэтгэгдэл:

Би Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжитээр хэрэгжсэн Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан хатгамал, оёдлын чиглэлээр 500,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсандаа баяртай байна.

Ажилгүй гэрээрээ байдаг эмэгтэйчүүдээ дэмжиж ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлсэнд маш их баяртай байгаа. Санхүүжилтээр хатгамлын бэлдэц авч, хатгамалаа оёж жаазлан зарж борлуулж байгаагаас гадна төсөлд хамрагдсан А. Дэлгэрэхийн оёдлын цехэд хамтран ажиллаж байнгын ажлын байртай бий болсон. Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн хамт олондоо баярлалаа.



25-Р ЦЭЦЭРЛЭГИЙН STEAM ХӨТӨЛБӨР

Төслийн үр шим хүртэгчийн нэр: 25-р цэцэрлэгийн сурагч О. Энхнаран

Сэтгэгдэл:

STEAM сургалтын талаар хийсэн ярилцлага



Эрхлэгч: Энхнаран аа, STEAM сургалт гэж мэдэх үү. STEAM-ын талаар юу гэж бодож байна. Юу сурч байна.

Энхнаран: Мэднэ. STEAM гоё. Өнгө үүсгэж үзсэн. Шилтэй усанд улаан, шар өнгө хийгээд улбар шар өнгө үүсгэсэн. Шар цэнхэр 2-оос ногоон өнгө үүсгэсэн.

Эрхлэгч: Өөр юу хийж үзсэн бэ? Энэ зүйлүүдийг ганцаараа хийсэн үү. Найзтайгаа хамтраад хийсэн үү.

Энхнаран: -Бид нар гурвуулаа хийдэг. Хамтдаа тооцоолж TIP- ээ авдаг. Бас норгож наадаг. Бас хайчилж бэлддэг.

Эрхлэгч: Тэгээд та нар юу юу хийж үзсэн бэ. Одоо TIP-ээр юу юу хийж үзмээр байна.

Энхнаран: Цаг чимэглэсэн. Завь хийсэн, байшин хөдөө нутаг, мод тахиа гээд зөндөөн олон зүйл хийсэн. Туршилт хийж үзмээр байна. Хүнд хөнгөн гээд зөндөө туршмаар байна.

Эрхлэгч: Чамд энэ хөтөлбөрийн юу нь таалагдаж байна?

Энхнаран: Гарт наалддаггүй, наахад амархан, хөгжилтэй байдаг. Надад маш их таалагдаж байгаа.

ИРЭЭДҮЙД ГЭРЭЛТЭХ НАС ХӨТӨЛБӨР

Төслийн үр шим хүртэгчийн нэр: Үе тэнгийн зөвлөгч, сургагч багш О.Уулсанаа

Сэтгэгдэл:

О.Уулсанаа миний бие 3-р сургуулийн 12-р ангийн сурагч бөгөөд Оюутолгой ХХК-ны хөрөнгө оруулалттай “Говийн оюу хөгжлийг дэмжих” сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Ирээдүйд гэрэлтэх нас” Бидний сонголт эрүүл ирээдүй уриатай үе тэнгийн сургагч багш бэлтгэх төсөлд хамрагдаж Үе тэнгийн зөвлөгч, сургагч багш болсондоо маш их баяртай байна. Урьд нь би хүний өмнө гарч чаддаггүй ичдэг байсан бол энэхүү төслийн сургалтанд суугаад өөрийгөө маш сайн нээж өглөө одоо би найз нөхөддөө мэдсэн сурсанаа түгээх бүрэн итгэлтэй болсон. Төслийн сургалтын арга хэлбэр нь хүүхдийн оролцоонд түшиглэсэн, бусдад нөлөөлөх арга замыг заасан, эрүүл дадал хэвшил олгох чиглэлээр олон шинэ мэдлэг мэдээлэл олгож өгсөнд баяртай байна.



Өсвөр насныханы дунд маш олон асуудал тулгардаг нэн ялангуяа үе тэнгийн дарамт шахалт, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, БЗДХ, эцэг, эхийн хайр халамжгүй байдал, амиа хорлолт, үерхэл хайр гэх мэт энэ асуудлыг яаж шийдвэрлэх талаар ямарч мэдлэггүй, хаана хандахаа мэддэггүй байсан бол “Ирээдүйд гэрэлтэх нас” төсөл хэрэгжсэн нь маш их цаг үеэ олсон үр дүнтэй байсан бөгөөд үе тэнгийн зөвлөгч нараар дамжуулан олон хүүхдэд мэдлэг олгох тэднийг аливаа эрсдэлтэй алхам хийхгүй байхад нь туслахад бидэнд их эрч хүч мэдлэгийг олгосон. Бид нар бүгд өөртөө итгэлтэй болж бусдад туслах чин хүсэлтэй болсон. Өсвөр үеийнхэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, бидний эрүүл мэндэд маш их анхаарч энэхүү төслөөр биднийг бэлтгэж өгсөнд баярлалаа цаашид их зүйл хийх болно.

“Говийн оюу хөгжлийн дэмжих” сангийн ах эгч нартаа баярлалаа, чадварлаг багш нартаа маш их баярлаж байна. Цаашид Өсвөр үеийнхэнд зориулсан олон сайхан төсөл хэрэгжээсэй гэж хүсэн хүлээж байна Бид эх орны ирээдүй бидэнд итгээрэй.

АХМАДУУДАД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Төслийн үр шим хүртэгчийн нэр: Ханбогд сумын Баян багийн ахмад настан Цэндоо (65 настай)



Сэтгэгдэл:

Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсандаа баяртай байна. Эмнэлгийн тусламжийг тэр бүр авч чаддаггүй. Манай сумын байгаль цаг уурын онцлог их эрс тэс уур амьсгалтай. Зундаа их хална. Би жин цохиод их удаж байгаа хүн. Энэ эрүүл мэндийн үзлэгээр уламжлалын эмчид үзүүлэн хануур төөнүүр, бумба тавиулаад бие их сайхан боллоо. Ийм арга хэмжээг ахмад настануудад цаашид үргэлж зохион байгуулж байвал их сайн байна.

Төслийн үр шим хүртэгчийн нэр: Даланзадгад сумын 6-р багийн иргэн Ж.Цагаандүү (79 настай)

Сэтгэгдэл:

Аймгийн ЗДТГ, Говийн Оюу хөгжлийг дэмжих сан, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагуудад болон хамт олонд нь хамгийн түрүүнд талархал илэрхийлье. “Ахмадуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх” хөтөлбөрийг ахмад настан биднийг өргөнөөр хамруулан хэрэгжүүлж, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тусгайлан өдөр гарган дугаарлах шаардлагагүйгээр түргэн шуурхай үзэж нарийн мэргэжлийн эмч нар өвчин эмгэгт тохирсон зөвлөгөө зөвлөмж өгч, нэн даруй хэвтэн эмчлүүлэх боломж олгосонд баярлаж байна. Би эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэр болгон аваад байж чаддаггүй. Ахмадыг жилд 1 удаа эрүүл мэндийн тусламжийг авч байх ийм үзлэг, оношилгоонд хамруулан даатгалаар хөнгөлөлттэй олддог эмийг сар бүр өгч байх хэрэгцээ бидэнд байдаг.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Говийн оюу хөгжлийг дэмжих сан нь холбогдох хууль тогтоомж болон өөрийн дүрмийн дагуу жил бүр хөндлөнгийн аудит хийлгэдэг. 2017 оны хувьд сангийнхаа 2015-2016 оны санхүү, үйл ажиллагаанд Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг, гаргасан дүгнэлт тайлан нь олон улсад хүлээн зөвшөөрөгддөг аудитын байгууллагуудад аудит хийлгэх урилга хүргүүлэн шаардлага хангах эрх бүхий аудитын байгууллагуудаас Монгол улсын анхны бөгөөд аудитын тэргүүлэгч компани Далайван Аудит ХХК иар аудит хийлгэлээ. Далайван аудит ХХК нь дэлхийн 131 улсын 156 байгууллагыг нэгтгэсэн аудит, нягтлан бодох бүртгэл, бизнесийн зөвлөх үйлчилгээний томоохон сүлжээ бүхий Бейкер Тилли Интернэшл (Baker Tilly International)-ийн Монгол улсыг төлөөлөх хараат бус бие даасан гишүүн аудитын байгууллага юм.

ДАЛАЙВАН АУДИТЫН ДҮГНЭЛТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Тодруулга (1) ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь 2015 оны 9-р сарын 23-ний өдөр No.8186995 регистрийн дугаар бүхий No.64947 дугаартай Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авснаар Төрийн бус байгууллагаар бүртгэгдэж, Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, Оюу Толгой ХХК-тай хамтран сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлтэй.

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ыг Удирдах Зөвлөл болон Удирдлагын баг удирдана. 2015 оны туршид дараах гишүүдтэй байсан.

Удирдах Зөвлөл

Нэр	Албан тушаал
Стивен Жонс	Удирдах Зөвлөлийн Дарга–Оюу Толгой ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал
Х. Сугир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
Н.Наранбаатар	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Засаг дарга
Б.Эрдэнэ-Очир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн ИТХ-ийн Ханбогд сумаас сонгогдсон төлөөлөгч
Майкл Гавин	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн Боловсон хүчин, бүтэц, зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер.
Д.Амарбаясгалан	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал
Ш.Байгалмаа	Удирдах Зөвлөлийн Гишүүн – Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер

Удирдлагын Баг

Нэр	Албан тушаал
С.Эрдэнэбат	Гүйцэтгэх Захирал
Б.Сугаржаргал	Төсөл хөтөлбөрийн ажилтан
Б.Батхуяг	Санхүүгийн ажилтан

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн албан ёсны хаяг:
Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Голомт бизнес төв, 4 давхар 404 тоот тоот Утас/Факс: 976-70533577/976-70533578, цахим шүүдэн: Info@goviinoymn

Тодруулга (2) ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан гол нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг дор харуулсан. Эдгээр бодлогуудыг бүх цаг хугацаанд тогтвортой ашигласан.

2.1 Санхүүгийн тайлагналын суурь

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар, мөнгөн сууриар бэлтгэгдсэн байна.

2.2 Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Сангийн Сайдын 385-р тушаалаар батлагдсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар-ын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өр төлбөр, санхүүгийн орлого, зардлаас бүрдэнэ.

2.3 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Хэрэв удирдлага байгууллагыг татан бүүлгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой гол шийдэл, төсөөлөл ба тооцоолол

СТОУС-д санхүүгийн тайлан бэлтгэхийн тулд нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон төсөөллийг ашиглахыг шаарддаг. Мөн Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын удирдлага нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад өөрийн шийдлийг гаргадаг. ТББ-ын удирдлага бүх боломжтой мэдээлэл болон туршлага дээрээ суурилан гаргасан тооцоолол, төсөөлөл болон шийдлээ байнга үнэлж үздэг. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан тооцоолол нь бодит байдлаас зөрүүтэй байж болно.

2.6 Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Санхүүгийн тайланг Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын бүртгэлийн валют болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний олз эсвэл гарзыг үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланд тусгагдана.

Тодруулга (3) НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

3.1 Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүдэд дараах хэрэглүүрүүдийг хамруулна:

- Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
- Дансны ба бусад авлага
- Дансны ба бусад өглөг

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

3.1.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх бэлэн мөнгө, банканд байгаа мөнгө болон 3 сар хүртэл хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө багтана.

3.1.2 Дансны ба бусад авлага

Авлагыг бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний зардлын нийлбэрээр анхлан хэмжинэ. Дараа үеүдэд нь үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үл хүлээн зөвшөөрөх, үнэ цэнэ буурах, хорогдуулгын хөтөлбөрийн үед үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сүмтэй “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-аас жил бүр 5,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгохоор заасан. Гэхдээ Оюу Толгой ХХК нь санхүүгийн дэмжлэгийг жилийн туршид хэсэгчлэн шилжүүлэх, шилжүүлэх цаг хугацаатай холбоотой шийдвэрийг гаргахдаа Оюу Толгой ХХК болон ба Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ын Удирдах зөвлөлтэй зөвшилцөж санхүүгийн дэмжлэгийг (эсвэл түүний зарим хэсгийг) өгч байх заалттай тул санхүүжилтийн авлага, орлогыг мөнгөн сууриар бүртгэдэг.

3.1.3 Дансны өр ба хуримтлагдсан өр төлбөр

Ханган нийлүүлэгчээс нэхэмжлэгдсэн үед хүлээн зөвшөөрөх бараа эсвэл үйлчилгээнд төлөх дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

3.2 Санхүүгийн бус хөрөнгө

3.2.1 Бараа материал

Бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлчилгээнд үзүүлэх хангамжийн зүйлс хамаарна.

Бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбогдон гарсан зардлуудыг бараа материалын өртөгт оруулж тооцдог. Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авсан үнэ, импортын хураамж болон бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас дараагийн үеүдэд тухайн аж ахуйн нэгжид нөхөн олгохоос бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээг худалдан авахтай шууд холбогдон гарах бусад зардлууд орно. Худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасаж худалдан авалтын өртгийг тодорхойлно.

Тайлант хугацааны эцэст бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлнэ. Ашиглалтад тавьж олгосон бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тооцно.

3.2.2 Үндсэн хөрөнгө

Тайлант үеийн эцэст өртгөөр илэрхийлэгдсэн үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр хэмжсэн. Түүхэн өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл компани тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг орлуулсан үед нь дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг дараах ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

<u>Ашиглалтын жил</u>	
Тавилга эд хогшил	10
Компьютер дагалдах хэрэгсэл	3

Тайлант хугацааны эцэст үндсэн хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг нягтлан үзэж шаардлагатай бол залруулна.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ нь тооцсон нөхөгдөх өртгөөс их тохиолдолд түүнийг нөхөгдөх өртөг хүртэл нь бууруулна.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

3.2.3 Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулалд ба аливаа үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан алдагдлыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгүүдийг эдийн засгийн үр ашигтай хугацааных нь туршид хорогдуулах бөгөөд биет бус хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон шинж тэмдэг илэрсэн үед үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийнэ. Сан нь 2015 онд ямар нэгэн программ хангамж, лиценз эзэмшээгүй байна.

3.2.4 Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөц

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч юм. Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч юм.

Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Хандивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд түр хугацаанд хязгаарлалт тавьсан бол уг зорилго эсвэл цаг хугацааг хангагдах үед орлого хүлээн зөвшөөрнө.
- андивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд аливаа хязгаарлалт тавиагүй бол нөөцийг олж авах үед орлого хүлээн зөвшөөрнө.

3.3 Санхүүгийн орлого, зардал

3.3.1 Үйлчилгээний төлбөр болон бусад орлого

Орлогыг үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

Оюу Толгой ХХК-тай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу орж ирсэн санхүүжилтийн орлогыг дараах нөхцөл бүрдсэн үед хүлээн зөвшөөрнө:

- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай байх
- Балансын өдрөөр тухайн ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг бодитойгоор тооцох боломжтой байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал болон ажил гүйлгээг гүйцээхэд гарсан өртгийг найдвартай хэмжих боломжтой байх.

3.3.2 Зардал хүлээн зөвшөөрөх

Зардлыг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрнө. Мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

3.4 Татварын бүртгэл

3.4.1 Орлогын татвар

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь ашгийн төлөө бус байгууллага учраас орлогын татвар тооцогдохгүй.

3.4.2 Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл

Төрийн бус байгууллагын ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу, хувь хүний орлогын албан татварыг “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тогтоосон хувь хэмжээгээр суутган авч харьяалагдах татварын хэлтэст төлж тайлагнана. Татварыг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэдэг.

Төрийн бус байгууллага нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг 11 хувиар тооцож, тухайн жилийн зардалд хүлээн зөвшөөрсөн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэдэг.

3.5 Холбоотой тал

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- (i) Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- (ii) Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,

(iii) Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- (i) Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
- (ii) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй группийн нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
- (iii) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
- (iv) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,
- (v) Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн “ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө”-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болно.
- (vi) Байгууллагад (1)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
- (vii) (1), (1)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,
- (viii) Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах,

3.6 Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээх магадлалтай, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн үрсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө.

Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Болзошгүй өр төлбөрийг тайлант хугацааны эцэст байгаа одоогийн үүрэг хариуцлагыг барагдуулахын тулд удирдлагын хийсэн шаардлагатай зардлын хамгийн сайн тооцооллын өнөөгийн үнэ цэнээр хэмжих бөгөөд төлөгдөх нь тодорхой болох хүртэл болзошгүй өр төлбөрийг зөвхөн тодруулна.

Тодруулга (4) САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.1. Тодруулга-Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

	2015.09.23 мянган төгрөг	2015.12.31 мянган төгрөг
Бэлэн мөнгө:		
Төгрөг	-	-
Банкин дахь харилцах:		
Төгрөг	-	974,166.1
Дүн	=	<u>974,166.1</u>
	2015.09.23	2015.12.31

	мянган төгрөг	мянган төгрөг
Банкин дахь харилцах:		
Төгрөг		
Хаан банк-5585698858	-	809,726.2
Хаан банк-5585644465	-	164,439.9
Дүн	-	974,166.1

Дээрх мөнгөний үлдэгдэл нь Даланзадгад суманд тус бүр 200 хүүхдийн хүчин чадал бүхий 25, 26 дугаар цэцэрлэгийн барилга угсралтын ажлын санхүүжилтад зарцуулагдах мөнгө байна.

4.2.Тодруулга-Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Барилга, байгууламж	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Нийт дүн
<u>Анхны өртөг:</u>				
2015.09.23-ний үлдэгдэл	=	=	=	=
Нэмэгдсэн:				
Худалдаж авсан		-	695.0	695.0
Хасагдсан:				
2015.12.31-ний үлдэгдэл	=	=	695.0	695.0
<u>Хуримтлагдсан элэгдэл:</u>				
2015.09.23-ний үлдэгдэл	=	=	=	-
Нэмж байгуулсан элэгдэл	-	-	-	-
Хасагдсан	-	-	-	-
2015.12.31-ний үлдэгдэл	=	=	=	=
<u>Үлдэгдэл өртөг:</u>				
2015.09.23-ний үлдэгдэл		=	=	=
2015.12.31-ний үлдэгдэл	=	=	695.0	695.0

4.3 Тодруулга-Цэвэр хөрөнгө

	2015.09.23 мянган төгрөг	2015.12.31 мянган төгрөг
Хязгаарлалтгүй нөөц	-	-
Хязгаарлалттай нөөц	-	-
Хуримтлагдсан үр дүн	-	974,861.1

Цэвэр хөрөнгийн дүн	=	<u>974,861.1</u>
---------------------	---	------------------

4.4 Тодруулга-Үндсэн үйл ажиллагааны орлого

		2015.12.31 мянган төгрөг
Оюу Толгой ХХК-аас өгсөн сайн дурын санхүүжилтын орлого		3,993,980.0
Нийт орлого		<u>3,993,980.0</u>

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ нь 2015.09.23-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Уг гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-аас тайлант онд 2,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний буюу 3,993,980.0 мянган төгрөг шилжүүлсэнийг орлогоор бүртгэж тайлагнасан.

4.5 Тодруулга- Үндсэн үйл ажиллагааны зардал

		2015.12.31 мянган төгрөг
Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн зардал		3,010,722.4
Үндсэн ба нэмэгдэл цалин		2,795.8
Нийгмийн даатгалын шимтгэл		307.5
Зар сурталчилгаа, хэвлэлийн зардал		448.9
Оффис түрээсийн зардал		2,475.0
Бичиг хэргийн зардал		226.6
Шуудан холбооны зардал		486.2
Хангамжийн материалын зардал		988.8
Засварын үйлчилгээний зардал		229.0
Тээврийн зардал		50.9
Бусад зардал		387.8
Дүн		<u>3,019,118.9</u>

Хамтын ажиллагааны гэрээний чиглэлийн дагуу тайлант онд Оюу Толгой ХХК-аас олгосон санхүүжилтийг дараах байдлаар зарцуулсан байна.

№	Санхүүжилт олгосон төсөл, хөтөлбөрийн нэр	Олгосон санхүүжилт
1	Даланзадгад сум, Шинэ суурьшилын бүсэд 25-р цэцэрлэгийн барилгын ажил	1,366,865.9

2	Даланзадгад сум, Гэр хороололд 26-р цэцэрлэгийн барилгын ажил	1,643,856.5
Дүн		3,010,722.4

4.7 Тодруулга - Холбоотой тал

Холбоотой талын нэр	Харьяалал	Хамаарал	Ажил гүйлгээ
Оюу Толгой ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Үүсгэн байгуулагч	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
Өмнөговь аймаг, Хан богд сум бүсад түншлэгч сум	Монгол улсын хуулийн этгээд	Хамтын ажилгааны гэрээний дагуу удирдан зохион байгуулагчид	Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хандив, дэмжлэг
Стивен Жонс	Канад улсын иргэн	Удирдах зөвлөлийн дарга	Хурал, уулзалт
Х. Сугир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Н.Наранбаатар	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Б.Эрдэнэ-Очир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Майкл Гавин	Канад улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Д.Аамарсайхан	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Ш.Байгалмаа	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
С.Эрдэнэбат	Монгол улсын иргэн	Гүйцэтгэх захирал	Цалин

4.8 Тодруулга-Болзошгүй өр төлбөр

2015 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

4.9 Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Тайлант хугацаа дуусгавар болсноос хойш 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн тайланд нөлөөлөх аливаа үйл явдал гараагүй байна.

Аудитын тайланг, тодруулгын хамт монгол, англи хэлээр тус бүр 2 хувь бэлтгэсэн бөгөөд эдгээрт утгын зөрүү гарвал монгол эх хувийг баримтлах болно.

ДАЛАЙВАН АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2016

Тодруулга (1) ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь 2015 оны 9-р сарын 23-ний өдөр No.8186995 регистрийн дугаар бүхий No.64947 дугаартай Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авснаар Төрийн бус байгууллагаар бүртгэгдэж, Өмнөговь аймгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, Оюу Толгой ХХК-тай хамтран сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлтэй.

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ыг Удирдах Зөвлөл болон Удирдлагын баг удирдана. 2016 оны туршид дараах гишүүдтэй байсан.

Удирдах Зөвлөл

Нэр	Албан тушаал
Стивен Жонс	Удирдах Зөвлөлийн Дарга–Оюу Толгой ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал
Х. Сугир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга
Н.Наранбаатар	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн Засаг дарга
Б.Эрдэнэ-Очир	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Өмнөговь аймгийн ИТХ-ийн Ханбогд сумаас сонгогдсон төлөөлөгч
Майкл Гавин	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн Боловсон хүчин, бүтэц, зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер.
Д.Амарбаясгалан	Удирдах Зөвлөлийн Гишүүн - Оюу Толгой ХХК-ийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал
Ш.Байгалмаа	Удирдах Зөвлөлийн Гишүүн – Оюу Толгой ХХК-ийн Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер

Удирдлагын Баг

<u>Нэр</u>	<u>Албан тушаал</u>
С.Эрдэнэбат	Гүйцэтгэх Захирал
Б.Сугаржаргал	Төсөл хөтөлбөрийн ажилтан
Б.Батхуяг	Санхүүгийн ажилтан

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн албан ёсны хаяг:

Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг, Голомт бизнес төв, 4 давхар 404 тоот тоот Утас/Факс: 976-70533577/976-70533578, цахим шуудан: www.goviinoyu.mn

2015, 2016 оны санхүүгийн тайлангийн хараат бус аудитор: Далайван Аудит ХХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5, Далайван Аудит Компанийн байр, Утас/Факс:976-70005401/70005403, цахим шуудан: info@dalaivanaudit.mn

Тодруулга (2) ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан гол нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг дор харуулсан. Эдгээр бодлогуудыг бүх цаг хугацаанд тогтвортой ашигласан.

2.1 Санхүүгийн тайлагналын суурь

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчмаар, мөнгөн сууриар бэлтгэгдсэн байна.

2.2 Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн Сангийн Сайдын 385-р тушаалаар батлагдсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар-ын дагуу бэлтгэгдсэн.

2.5 Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өр төлбөр, санхүүгийн орлого, зардлаас бүрдэнэ.

2.6 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

2.7 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой гол шийдэл, төсөөлөл ба тооцоолол

СТОУС-д санхүүгийн тайлан бэлтгэхийн тулд нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон төсөөллийг ашиглахыг шаарддаг. Мөн Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын удирдлага нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад өөрийн шийдлийг гаргадаг. ТББ-ын удирдлага бүх боломжтой мэдээлэл болон туршлага дээрээ суурилан гаргасан тооцоолол, төсөөлөл болон шийдлээ байнга үнэлж үздэг. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан тооцоолол нь бодит байдлаас зөрүүтэй байж болно.

2.6 Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Санхүүгийн тайланг Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ын бүртгэлийн валют болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрийн Монгол банкны зарласан хаалтын ханшийг ашиглан Монгол төгрөг рүү хөрвүүлдэг. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүний олз эсвэл гарзыг үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайланд тусгагдана.

Тодруулга (3) НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

3.5 Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүдэд дараах хэрэглүүрүүдийг хамруулна:

- Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
- Дансны ба бусад авлага
- Дансны ба бусад өглөг

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

3.1.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх бэлэн мөнгө, банканд байгаа мөнгө болон 3 сар хүртэл хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө багтана.

3.1.2 Дансны ба бусад авлага

Авлагыг бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний зардлын нийлбэрээр анхлан хэмжинэ. Дараа үеүдэд нь үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үл хүлээн зөвшөөрөх, үнэ цэнэ буурах, хорогдуулгын хөтөлбөрийн үед үүссэн аливаа олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-аас жил бүр 5,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгохоор заасан. Гэхдээ Оюу Толгой ХХК нь санхүүгийн дэмжлэгийг жилийн түршид хэсэгчлэн шилжүүлэх, шилжүүлэх цаг хугацаатай холбоотой шийдвэрийг гаргахдаа Оюу Толгой ХХК болон ба Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ын Удирдах зөвлөлтэй зөвшилцөж санхүүгийн дэмжлэгийг (эсвэл түүний зарим хэсгийг) өгч байх заалттай тул санхүүжилтийн авлага, орлогыг мөнгөн сууриар бүртгэдэг.

3.1.3 Дансны өр ба хуримтлагдсан өр төлбөр

Ханган нийлүүлэгчээс нэхэмжлэгдсэн үед хүлээн зөвшөөрөх бараа эсвэл үйлчилгээнд төлөх дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

3.6 Санхүүгийн бус хөрөнгө

3.2.1 Бараа материал

Бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлчилгээнд үзүүлэх хангамжийн зүйлс хамаарна.

Бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбогдон гарсан зардлуудыг бараа материалын өртөгт оруулж тооцдог. Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авсан үнэ, импортын хураамж болон бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас дараагийн үеүдэд тухайн аж ахуйн нэгжид нөхөн олгохоос бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээг худалдан авахтай шууд холбогдон гарах бусад зардлууд орно. Худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасаж худалдан авалтын өртгийг тодорхойлно.

Тайлант хугацааны эцэст бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлнэ. Ашиглалтад тавьж олгосон бараа материалыг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар тооцно.

3.2.2 Үндсэн хөрөнгө

Тайлант үеийн эцэст өртгөөр илэрхийлэгдсэн үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр хэмжсэн. Түүхэн өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл компани тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг орлуулсан үед нь дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг дараах ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

Ашиглалтын жил

Тавилга эд хогшил	10
Компьютер дагалдах хэрэгсэл	3

Тайлант хугацааны эцэст үндсэн хөрөнгийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг нягтлан үзэж шаардлагатай бол залруулна.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ нь тооцсон нөхөгдөх өртгөөс их тохиолдолд түүнийг нөхөгдөх өртөг хүртэл нь бууруулна.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

3.2.3 Биет бус хөрөнгө

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулалд ба аливаа үнэ цэнийн бууралтын хуримтлагдсан алдагдлыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгүүдийг эдийн засгийн үр ашигтай хугацааных нь түршид хорогдуулах бөгөөд биет бус хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон шинж тэмдэг илэрсэн үед үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийнэ. Сан нь 2015, 2016 онд ямар нэгэн программ хангамж, лиценз эзэмшээгүй байна.

3.2.4 Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөц

Хязгаарлалттай нөөц нь хандивлагчийн зүгээс эсвэл хуулийн дагуу ашиглалтын нөхцөлд нь хязгаарлалт тавьсан өмч юм. Хязгаарлалтгүй нөөц нь төрийн бус байгууллагын бүрэн мэдэлд байгаа өмч юм.

Хязгаарлалттай болон хязгаарлалтгүй нөөцийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Хандивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд түр хугацаанд хязгаарлалт тавьсан бол уг зорилго эсвэл цаг хугацааг хангагдах үед орлого хүлээн зөвшөөрнө.
- андивлагч эсвэл хуулийн дагуу зорилго эсвэл цаг хугацааны хувьд аливаа хязгаарлалт тавиагүй бол нөөцийг олж авах үед орлого хүлээн зөвшөөрнө. X

3.7 Санхүүгийн орлого, зардал

3.7.1 Үйлчилгээний төлбөр болон бусад орлого

Орлогыг үзүүлэхээр зөвшөөрсөн аливаа худалдааны хөнгөлөлт, урамшууллын дүнг харгалзаж үзэн хүлээж авсан эсвэл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

Оюу Толгой ХХК-тай байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу орж ирсэн санхүүжилтийн орлогыг дараах нөхцөл бүрдсэн үед хүлээн зөвшөөрнө:

- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай байх
- Балансын өдрөөр тухайн ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг бодитойгоор тооцох боломжтой байх
- Тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан зардал болон ажил гүйлгээг гүйцээхэд гарсан өртгийг найдвартай хэмжих боломжтой байх.

3.3.2 Зардал хүлээн зөвшөөрөх

Зардлыг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу гарсан үед нь хүлээн зөвшөөрнө. Мөнгөний гадагш үрсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

3.8 Татварын бүртгэл

3.4.1 Орлогын татвар

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ нь ашгийн төлөө бус байгууллага учраас орлогын татвар тооцогдохгүй.

3.4.2 Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл

Төрийн бус байгууллагын ажиллагсдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу, хувь хүний орлогын албан татварыг “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тогтоосон хувь хэмжээгээр суутган авч харьяалагдах татварын хэлтэст төлж тайлагнана. Татварыг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэдэг.

Төрийн бус байгууллага нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг 11 хувиар тооцож, тухайн жилийн зардалд хүлээн зөвшөөрсөн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг төлөлтөөс хамаарахгүйгээр ногдуулсан үед бүртгэдэг.

3.5 Холбоотой тал

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- (iv) Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- (v) Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,
- (vi) Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- (ix) Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
- (x) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй группийн нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
- (xi) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
- (xii) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,
- (xiii) Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн “ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө”-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болно.
- (xiv) Байгууллагад (1)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
- (xv) (1), (1)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,

(xvi) Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани рүү гол удирдлагын ажилтнаар хангах,

3.6 Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээх магадлалтай, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө.

Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Болзошгүй өр төлбөрийг тайлант хугацааны эцэст байгаа одоогийн үүрэг хариуцлагыг барагдуулахын тулд удирдлагын хийсэн шаардлагатай зардлын хамгийн сайн тооцооллын өнөөгийн үнэ цэнээр хэмжих бөгөөд төлөгдөх нь тодорхой болох хүртэл болзошгүй өр төлбөрийг зөвхөн тодруулна.

Тодруулга (4) САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.1. Тодруулга-Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

	2015.12.31	2016.12.31
	мянган төгрөг	мянган төгрөг
Бэлэн мөнгө:		
Төгрөг	-	20.0
Банкин дахь харилцах:		
Төгрөг	974,166.1	6,768,726.2
Дүн	<u>974,166.1</u>	<u>6,768,726.2</u>

	2015.12.31	2016.12.31
	мянган төгрөг	мянган төгрөг
Банкин дахь харилцах:		
<i>Төгрөг</i>		
Хаан банк-5585698858	809,726.2	5,953,411.8
Хаан банк-5585638869	-	-
Хаан банк-5585644465	164,439,9	186,007.2
Хаан банк-5585673454	-	60,799.4
Хаан банк-5585672708	-	167,493.8
Хаан банк-5585675200	-	200,498.0
Дүн	974,166.1	6,568,210.2
Хаан банк- хадгаламж 5585675222	-	200,496.0
Дүн		200,496,0
Мөнгөн хөрөнгийн дүн	<u>974,166.1</u>	<u>6,768,706.2</u>

Дээрх мөнгөн хөрөнгө нь тайланд онд Сангийн удирдах зөвлөлөөс санхүүжүүлэхээр баталсан төсөл санхүүжүүлэх гэрээний дагуу зарцуулагдах мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан ТББ-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны №03 тоот тогтоолоор баталсан “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх санхүүжилтийн удирдамж”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Хойч үеийн төлөө сан, мөн Удирдах зөвлөлийн 2016 оны 9 сарын 19-ний өдрийн №05 тоот тогтоолоор баталсан “Өмнөговийн ирээдүй хойч үеийн төлөө сан”-ийн журмыг тус тус үндэслэн 2016 оны 12 сарын 20-ний өдөр Өмнөговь аймгийн Хаан банкны салбарт 100,000 ам.доллартай тэнцэх хэмжээний буюу 200,496.0 мянган төгрөгийн хадгаламжийг 1 жилийн хугацаатай, сарын 1.3 хувь (жилийн 16 хувь) хүү тооцуулж байх хадгаламжийн гэрээг байгуулсан. Талууд гэрээг жил бүр сунгалт хийж нийт 10 жилийн хугацаатай байхаар гэрээ байгуулсан байна.

4.2.Тодруулга-Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Орон сууцны барилга	Бусад барилга, байгууламж	Тавилга эд хогшил	Компьютер, дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Нийт дүн
<u>Анхны өртөг:</u>						
2015.12.31-ний үлдэгдэл	=	=	=	<u>695.0</u>	=	<u>695.0</u>
Нэмэгдсэн:						
Худалдаж авсан			4,000.0	9,665.0	-	13,665.0
Хасагдсан:						
2016.12.31-ний үлдэгдэл	=	=	<u>4,000.0</u>	<u>10,360.0</u>	=	<u>14,360.0</u>
<u>Хуримтлагдсан элэгдэл:</u>						
2015.12.31-ний үлдэгдэл	=	=	=	=	=	-
Нэмж байгуулсан элэгдэл	-	-	95.0	2,385.8	-	2,480.8

Хасагдсан	-	-	-	-	-
2016.12.31-ний үлдэгдэл	-	-	<u>95.0</u>	<u>2,385.8</u>	-
<hr/>					
<u>Үлдэгдэл өртөг:</u>					
2015.12.31-ний үлдэгдэл	-	-	<u>695.0</u>	-	<u>695.0</u>
2016.12.31-ний үлдэгдэл	-	-	<u>3,905.0</u>	<u>7,974.2</u>	-
<hr/>					

4.3 Тодруулга-Цэвэр хөрөнгө

	2015.12.31	2016.12.31
	мянган төгрөг	мянган төгрөг
Хязгаарлалтгүй нөөц	-	-
Хязгаарлалттай нөөц	-	-
Хуримтлагдсан үр дүн	974,861.1	6,780,605.4
Цэвэр хөрөнгийн дүн	<u>974,861.1</u>	<u>6,780,605.4</u>

4.4 Тодруулга-Үндсэн үйл ажиллагааны орлого

	2015.12.31	2016.12.31
	мянган төгрөг	мянган төгрөг
Оюу Толгой ХХК-аас өгсөн сайн дурын санхүүжилтын орлого	3,993,980.0	10,024,900.0
Нийт орлого	<u>3,993,980.0</u>	<u>10,024,900.0</u>

Оюу Толгой ХХК нь 2015 оны 4 сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг болон Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний 8.1 дэх заалтын дагуу гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор “Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” ТББ-ыг үүсгэн байгуулж, гэрээний 8.3-т заасны дагуу Оюу Толгой ХХК-аас жил бүр 5,000,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн санхүүжилтийг олгохоор заасан ба тус заалтын дагуу Оюу Толгой ХХК-аас шилжүүлсэн санхүүгийн дэмжлэгийг орлогоор бүртгэсэн.

4.5 Тодруулга- Үндсэн үйл ажиллагааны зардал

2015.12.31	2016.12.31
мянган төгрөг	мянган төгрөг

Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн зардал	3,010,722.4	4,051,415.4
Үндсэн ба нэмэгдэл цалин	2,795.8	63,171.4
Нийгмийн даатгалын шимтгэл	307.5	6,948.9
Удирдах зөвлөхийн хурлын зардал	-	30,682.6
Зар сурталчилгаа, хэвлэлийн зардал	448.9	23,098.0
Оффис түрээсийн зардал	2,475.0	14,850.0
Сургалтын зардал	-	14,150.4
Бичиг хэргийн зардал	226.6	3,972.8
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	-	2,449.4
Элэгдлийн зардал	-	2,480.8
Шуудан холбооны зардал	486.2	2,255.0
Хангамжийн материалын зардал	988.8	1,928.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	-	1,026.3
Засварын үйлчилгээний зардал	229.0	635.0
Тээврийн зардал	50.9	91.6
Бусад зардал	387.8	-
Дүн	<u>3,019,118.9</u>	<u>4,219,155.7</u>

Хамтын ажиллагааны гэрээний чиглэлийн дагуу тайлант онд Оюу Толгой ХХК-аас олгосон санхүүжилтийг дараах байдлаар зарцуулсаныг ангилж харуулбал.

	Төслийн чиглэлээр	Зарцуулсан зардал:	
		мянган төгрөг	
		2015.12.31	2016.12.31
(i)	Нийгмийн дэд бүтэц, барилга	3,010,722.4	2,733,625.0
(ii)	Байгаль орчин менежмент	-	282,863.9
(iii)	Нийгэмд чиглэсэн сургалт, үйлчилгээ	-	171,598.0
(iv)	Мал аж ахуй, бэлчээрийн менежмент	-	386,585.6

(v)	Түүх соёлын өв, аялал жуулчлал	-	404,297.7
(vi)	Хандив, тусламж	-	33,000.0
(vii)	Тэтгэлэгт хөтөлбөр	-	39,445.2
		-	
	Дүн	<u>3,010,722.4</u>	<u>4,051,415.4</u>

Дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

№	Санхүүжилт олгосон төсөл, хөтөлбөрийн нэр	Олгосон санхүүжилт
1	Даланзадгад суманд 2015 онд хэрэгжүүлсэн 25-р цэцэрлэгийн барилга угсралтын ажил үлдэгдэл төлбөр	364,497.6
2	Даланзадгад суманд 2015 онд хэрэгжүүлсэн 26-р цэцэрлэгийн барилга угсралтын ажил үлдэгдэл төлбөр	438,279.4
3	Даланзадгад суманд 2-р сургуулийн спорт заал барилга угсралтын ажил	757,037.5
4	Баян-Овоо сумын 10 ортой эмнэлэгийн барилга угсралтын ажил	1,033,910.4
5	Ханбогд сумын СЦК-ны зураг төслийн барилга угсралтын ажил	128,900.0
6	Ханбогд сумын сум дундын “Малын эрүүл мэндийн төв”-ийн барилга угсралтын ажил	11,000.0
7	“Оюу хүлэмж” хөтөлбөр	150,000.0
8	Хан богд сумын “мод үржүүлэг” хөтөлбөр	61,077.1
9	Манлай сумын “Говийн ойн төгөл” хөтөлбөр	71,786.8
10	Өмнөговь аймгийн сумдад “сургалт” хөтөлбөр	14,785.0
11	Хотын соёл хөтөлбөр	56,813.0
12	Эрүүл малчин хөтөлбөр	100,000.0
13	Ариутгал-2016	386,585.6
14	Манлай сумын Музей	36,297.7
15	Манлай сумын “Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай холлуулан хөгжүүлэх хөтөлбөр	368,000.0

16	Хандив, тусламж	33,000.0
17	Говийн оюу “Оюутны тэтгэлэг” хөтөлбөр	39,445.2
Дүн		4,051,415.4

4.10Тодруулга - Холбоотой тал

Холбоотой талын нэр	Харьяалал	Хамаарал	Ажил гүйлгээ
Оюу Толгой ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Үүсгэн байгуулагч	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
Өмнөговт аймаг, Хан богд сум бүсад түншлэгч сум	Монгол улсын хуулийн этгээд	Хамтын ажилгааны гэрээний дагуу удирдан зохион байгуулагчид	Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хандив, дэмжлэг
Стивен Жонс	Австрали улсын иргэн	Удирдах зөвлөлийн дарга	Хурал, уулзалт
Х. Сугир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Н.Наранбаатар	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Б.Эрдэнэ-Очир	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Майкл Гавин	Австрали улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Д.Амар баясгалан	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
Ш.Байгалмаа	Монгол улсын иргэн	Удирдах Зөвлөлийн Гишүүн	Хурал, уулзалт
С.Эрдэнэбат	Монгол улсын иргэн	Гүйцэтгэх захирал	Цалин

4.11Тодруулга-Болзошгүй өр төлбөр

2016 оны жилийн эцсийн байдлаар өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэлээр хүлээсэн ямар нэг үүрэг хариуцлага байхгүй.

4.12Тайлагналын өдрийн дараах үйл явдал

Тайлант хугацаа дуусгавар болсноос хойш 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд санхүүгийн тайланд нөлөөлөх аливаа үйл явдал гараагүй байна.

Аудитын тайланг, тодруулгын хамт монгол,англи хэлээр тус бүр 2 хувь бэлтгэсэн бөгөөд эдгээрт утгын зөрүү гарвал монгол эх хувийг баримтлах болно.

ДАЛАЙВАН АУДИТ ХХК

2017 оны 12 дүгээр сарын 13